



## **“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ**



## **Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөхийн тайлан**



## **Явцын тайлан: 2017 оны 10-р сар**



**Баримт бичгийн дугаар. 13-391-Н11 Хувилбар 0 – 2018 оны 3-р сар**

**“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ**

**Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөхийн тайлан  
Явцын тайлан: 2017 оны 10-р сар**

<b>Тайлангийн хувилбар</b>	<b>Гарсан огноо</b>
I төсөл	2017 оны 12-р сарын 11
II төсөл	2018 оны 1-р сарын 14
III төсөл	2018 оны 1-р сарын 30, 2018 оны 2-р сарын 7
Эцэслэсэн хувилбар	2018 оны 5-р сарын 5

**Хэнд зориулсан:**

Давуу эрхтэй зээлдүүлэгчдийн групп

**Багийн гишүүд:**

Жиованни Ди Франчи	Төслийн менежер, багийн ахлагч – Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны мэргэжилтэн
Роберт Сноу	Ахлах хянагч – Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, уул уурхайн мэргэжилтэн
Дана Стренг	Байгаль орчин/Гидрологийн мэргэжилтэн
Эми Сэкстон, Анжела Рийман	Нийгмийн харилцаа/Орон нутгийн харилцааны асуудал хариуцсан мэргэжилтнүүд
Ровена Смац, Жоанна Трийвик	Биологийн олон янз байдлын мэргэжилтэн

**RINA Consulting S.p.A.**

Società soggetta a direzione e coordinamento amministrativo e finanziario del socio unico RINA S.p.A.  
Via San Nazaro, 19 - 16145 Genova

Tel. +39 010 3628148 - Fax +39 010 3621078 - www.rinaconsulting.org - rinaconsulting@rinaconsulting.org  
C.F. / P. IVA / R.I. Genova N. 03476550102 - Cap. Soc. € 20.000.000,00 i.v.

All rights, including translation, reserved. No part of this document may be disclosed to any third party, for purposes other than the original, without written consent of RINA Consulting S.p.A.

## ГАРЧИГ

ХҮСНЭГТ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
ЗУРАГ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛАЛ	2
ЕРӨНХИЙ ХУРААНГУЙ	5
1 УДИРТГАЛ	19
2 ТӨСЛИЙН ТОЙМ	20
2.1 БАРИЛГА, АШИГЛАЛТЫН ЯВЦ	20
2.2 ТАЙЛАНГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	21
3 ЗӨРЧЛИЙН ХҮСНЭГТ	22

## 1 ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛАЛ

<b>АЯХХМТ</b>	Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөө
<b>АЧХШТ</b>	Агаарын чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөө
<b>АХАГУБ</b>	Агаарын хөлгийн аврах, гал унтраах баг
<b>БОЯБУАТ</b>	Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө
<b>БОЯБУМХ</b>	Биологийн олон янз байдлын үнэлгээ, хяналт шинжилгээний хөтөлбөр
<b>БОЯБМТ</b>	Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө
<b>БТБМТ</b>	Бизнесийн тогтвортой байдлын менежментийн төлөвлөгөө
<b>ХДХЗО</b>	Хууль дүрмийн хэрэгжилтийн зөвлөх Омбудсман
<b>БОЯБУХШ</b>	Биологийн олон янз байдлын үндсэн хяналт шинжилгээ
<b>НЭХТМ</b>	Ноцтой эрсдэлийн хяналтын талбайн магадлагаа
<b>НЭХМ</b>	Ноцтой эрсдэлийн хяналтын магадлагаа
<b>ХХБХШС</b>	Хүлэмжийн хийн байнгын хяналт шинжилгээний систем
<b>ГЕЗ</b>	Гүйцэтгэх ерөнхий захирал
<b>СӨ</b>	Соёлын өв
<b>СӨМТ</b>	Соёлын өвийн менежментийн Төлөвлөгөө
<b>СӨМС</b>	Соёлын өвийн менежментийн систем
<b>ДТС</b>	Дулааны Төв Станц
<b>ОНЭМАААБМТ</b>	Орон Нутгийн Эрүүл Мэнд, Аюулгүй ажиллагаа, Аюулгүй Байдлын Менежментийн Төлөвлөгөө
<b>ИХТ</b>	Иргэдийн хөгжлийн төв
<b>ТШХО</b>	Том ширхэгт хүдрийн овоолго
<b>НЭМ</b>	Ноцтой эрсдэлийн менежмент
<b>ОНТО</b>	Орон нутаг, талуудын оролцоо
<b>ОНТОХС</b>	Орон Нутаг, Талуудын Оролцоог Хянах Систем
<b>ОНХНХ</b>	Орон Нутгийн Харилцаа, Нийгмийн Хариуцлага
<b>ОНХНХМС</b>	Орон Нутгийн Харилцаа, Нийгмийн Хариуцлагын Менежментийн Систем
<b>ХДС</b>	Хөгжлийг дэмжих сан
<b>ЕСБХБ</b>	Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк
<b>ЦДЧ</b>	Цахилгаан дамжуулах чанар
<b>ЭЗА</b>	Экспортын Зээлийн Агентлагууд
<b>КЭХА</b>	Канадын Экспортын Хөгжлийн агентлаг
<b>ЭСДК</b>	Экспортын Санхүү, Даатгалын Корпораци
<b>МТ</b>	Малчдын төлөөлөл
<b>ОБУББААХТ</b>	Онцгой байдлын үеийн бэлэн байдал, авах арга хэмжээний төлөвлөгөө
<b>ХХ</b>	Хөдөлмөрийн харилцаа
<b>ОБТ</b>	Онцгой байдлын төлөвлөгөө
<b>ОБУААХЖ</b>	Онцгой байдлын үед авах арга хэмжээний журам
<b>ОББ</b>	Онцгой байдлын баг
<b>БОНУАТ</b>	Байгаль Орчин, Нийгмийн Үйл Ажиллагааны Төлөвлөгөө
<b>БОННУ</b>	Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ
<b>БОНМТ</b>	Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
<b>ЭҮҮХШТ</b>	Экосистемийн үйлчилгээний үнэлгээ, хяналт шинжилгээний төлөвлөгөө
<b>ОУБОЯБХ</b>	Олон улсын биологийн олон янз байдлын хамгаалал
<b>ГХ</b>	Гүний хоолой
<b>ХХЯ</b>	Хүлэмжийн хийн ялгаралт
<b>СОУТТ</b>	Салбарын олон улсын тэргүүн туршлага
<b>ХН</b>	Хүний нөөц

**АрАйЭнЭй Консалтинг компани**

**“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ**

<b>ЭМААБО</b>	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин
<b>ЭМААБООНМС</b>	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутгийн менежментийн систем
<b>ЭМААБООН</b>	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутаг
<b>ЭМААБООН</b>	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал, орон нутаг
<b>БОНХЗ</b>	Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөх
<b>ХШЗ</b>	Хөндлөнгийн шинжээчдийн зөвлөл
<b>ОУСК</b>	Олон Улсын Санхүүгийн Корпорац
<b>ОУСБ</b>	Олон Улсын Санхүүгийн Байгууллага
<b>ХАШИХМТ</b>	Хүн амын шилжин ирэх хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө
<b>ДБХТХТ</b>	Дахин боловсруулах хаягдал түр хадгалах төв
<b>ККБ</b>	Клохн Криппен Бергер
<b>ГҮҮ</b>	Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд
<b>ЗБОЯБУАТ</b>	Зээлдүүлэгчдийн шаардсан Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө
<b>ГХХНСМТ</b>	Газар хөндөлтийн хяналт ба нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө
<b>ГХЗ</b>	Газар хөндөх зөвшөөрөл
<b>АХМТ</b>	Ажиллах хүчний менежментийн төлөвлөгөө
<b>ХЧАОГ</b>	Хөдөлмөрийн чадвар алдсан осол гэмтэл
<b>ХЧАОГДХ</b>	ХЧАОГ-ийн давтамжийн хэмжээ
<b>ГАМТ</b>	Газар Ашиглалтын Менежментийн Төлөвлөгөө
<b>ШУА</b>	Шинжлэх ухааны академи
<b>ОТШБ</b>	Олон талт шинжээчдийн баг
<b>БОНХЯ</b>	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
<b>ОТБГА</b>	Олон талын баталгаа гаргагч агентлаг
<b>УЛТ</b>	Уурхайн лицензийн талбай
<b>ӨМ</b>	Өөрчлөлтийн менежмент
<b>ШУТИС</b>	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
<b>ЭХМТ</b>	Эрдэс хаягдлын менежментийн төлөвлөгөө
<b>ХҮЧ-гүй</b>	Хүчил Үүсгэх чадвартай
<b>ӨМ</b>	Өөрчлөлтийн мэдэгдэл
<b>НУУТ</b>	Нутгийн ургамал үржүүлгийн төв
<b>ЦЭН</b>	Цэвэр эерэг нөлөөлөл
<b>ДХМТ</b>	Дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө
<b>ОТ</b>	Оюу толгой
<b>ОТ-ГС</b>	Оюу толгой – Гашуун Сухайт
<b>ОТ-ХБ</b>	Оюу толгой – Ханбогд
<b>ХҮЧ-тай</b>	Хүчил Үүсгэх Чадвартай
<b>БОХОХШ</b>	Байгаль орчны хамтын оролцоотой хяналт шинжилгээ
<b>БАСМТ</b>	Бэлчээр, амьжиргаа сайжруулах менежментийн төлөвлөгөө
<b>БМТ</b>	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө
<b>ГШ</b>	Гүйцэтгэлийн Шаардлага
<b>ГС</b>	Гүйцэтгэлийн Стандарт
<b>НШУАТ</b>	Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө
<b>РТ</b>	Рио Тинто
<b>РТБШ</b>	Рио Тинто Бизнес Шийдэл
<b>СЧБ</b>	Стандарт чартеред банк
<b>ОТХАТ</b>	Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө

**АрАйЭнЭй Консалтинг компани**

**“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ**

<b>ОЗЗТА</b>	Орон зайн загварчлал, тайлагналын арга
<b>АХХ</b>	Ажлын хамрах хүрээ
<b>ТХГ</b>	Тусгай хамгаалалттай газар
<b>УХБНХ</b>	Ууссан хатуу бодисын нийт хэмжээ
<b>ТМТ</b>	Тээврийн менежментийн төлөвлөгөө
<b>ГТЗ</b>	Гурван талт зөвлөл
<b>т/хон</b>	тонн/хоног
<b>ХХБ</b>	Хаягдал хадгалах байгууламж
<b>ГУ</b>	Гүний уурхай
<b>АНУ ЭИБ</b>	АНУ-ын экспорт импортын банк
<b>ЧУП</b>	Чичиргээт, утастай пьезометр
<b>ЗАХН</b>	Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг
<b>ХХМТ</b>	Хог хаягдлын менежментийн төв
<b>УХШТ</b>	Усны хяналт шинжилгээний төлөвлөгөө
<b>ХЧО</b>	Хаягдал чулуулгийн овоолго
<b>УНМТ</b>	Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө

## ЕРӨНХИЙ ХУРААНГУЙ

Оюу толгой төсөл нь (цаашид “Төсөл” буюу “ОТ төсөл” гэнэ) Өмнөговь аймгийн Ханбогд суманд<sup>1</sup> байрлах, дэлхийд томоохонд тооцогдох зэс-алтны уурхайн төсөл юм. Уг төсөл нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт ойролцоогоор 600 км, Монгол-Хятадын хилээс хойш 80 км-т, Өмнийн говийн бүс нутагт байрладаг. Тус орд нь зэс, алт, мөнгө болон бага хэмжээний молибден бүхий хэд хэдэн бүлэг ордоос бүрдэнэ. Уг төслийг Монгол улсын засгийн газрын бүрэн эзэмшлийн Эрдэнэс оюу толгой (34 хувь) компани, Туркуойз хилл ресурс (66 хувь) компаниудын хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж болох “Оюу толгой” ХХК хэрэгжүүлж байна. Рио Тинто (РТ) нь Туркуойз хилл ресурс компанийн гол хувьцаа эзэмшигч бөгөөд 2010 оноос хойш бүх хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн уг төслийг албан ёсоор удирдаж байна. Уг төсөл нь одоо үйл ажиллагаа явуулж байгаа зэс-алтны ил уурхай, түүнээс гарсан хүдрийг боловсруулах үйл ажиллагаа, зэс-алтны гүний уурхайн бүтээн байгуулалт, барилга угсралт, ашиглалтын үйл ажиллагаанаас бүрдэнэ.

2013 оны 9-р сараас эхлэн Итали улсын Генуя хотод байрлах Д'Апполониа компани (2017 оны 6 дугаар сарын 5-наас хойш АрАЙЭНЭЙ Консалтинг болсон)<sup>2</sup> Оюу толгой төслийг санхүүжүүлж буй давуу эрхтэй Зээлдүүлэгчдийн<sup>3</sup> группийг төлөөлөх Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөх (БОНХЗ)-өөр томилогдсон билээ.

БОНХЗ нь баримт бичигт тулгуурласан аудит хийхээс гадна Төслийн талбайд хуваарийн дагуу очиж шалгалт хийн, уг Төсөл хүлээсэн үүрэг амлалтаа Зээлдүүлэгчдийн холбогдох стандарт шаардлагын дагуу биелүүлж буй эсэхэд хяналт тавих үндсэн үүрэгтэй. Тодруулбал:

- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө болон БОНУАТ-нд тодорхойлсон үүрэг хариуцлагын хэрэгжилт, биелэлтэд үнэлгээ хийх;
- УАМТ, БОНУАТ-ний амлалт үүрэгтэй холбоотой аливаа зөрчил /дутагдлыг илрүүлэх, илэрсэн тохиолдолд Салбарын олон улсын тэргүүн туршлага (СОУТТ)<sup>4</sup> -д үндэслэн зөрчил, дутагдал арилгах санал зөвлөмж өгөх;
- БОНХЗ-ийн 2017 оны 5-р сард уурхайд ажилласан тайланд<sup>5</sup> дурдсан тодорхой асуудал/зөрчлийг тодорхойлж, түүний мөрөөр арга хэмжээ авч, зөрчил, ажиглагдсан зүйлсийг хаах үүрэгтэй.

Энэхүү тайланд БОНХЗ-ийн 2017 оны 10-11-р сард хийсэн баримт бичигт тулгуурлан хийсэн аудит, мөн хугацаанд Оюу толгой уурхайн талбайн ажилтнуудтай хийсэн теле-хэлэлцүүлгийн үр дүнг дэлгэрэнгүй тусгасан. Аудитын үндсэн зорилго нь төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны сүүлийн үеийн баримт мэдээлэлд шинжилгээ хийх, БОНХЗ уурхайн талбайд хамгийн сүүлд ажилласнаас хойш төслөөс мэдээлсэн аливаа зөрчил дутагдал, нөлөөллийг авч үзэх, улмаар Төслөөс хэрэгжүүлж буй нөлөөлөл бууруулах арга хэмжээ шаардлагын дагуу хэрэгжиж байгаа эсэхийг тодорхойлох зорилготой.

Аудит нь төслийн талбайд хийх “стандарт” шалгалтаар гүйцэтгэлийг нь шалгах шаардлагатай сэдвүүдийг хамраагүй. Эдгээр сэдвүүдийг 2018 оны 2-р улиралд буюу дараагийн төслийн талбайд ажиллах үеэр авч үзнэ. Түүнчлэн, усны бие даасан аудит 2017 оны 12-р сард усны бие даасан аудит хийгдэхээр төлөвлөгдсөн тул энэхүү аудитад усны нөөцийн холбогдолтой сэдвүүдийг оруулаагүй.

<sup>1</sup> Сум гэдэг нь Монгол Улсын засаг захиргааны хоёр дахь түвшний нэгж юм. Одоогийн байдлаар Монгол улсад 300 орчим сум байна.

<sup>2</sup> 6-р сарын 5-нд Д'Апполониа компани болон АрАЙЭНЭЙ группийн бусад инженерингийн зөвлөх компаниуд нэгдэж, АрАЙЭНЭЙ Консалтинг компанийг үүсгэсэн. Тиймээс АрАЙЭНЭЙ Консалтинг нь Д'Апполониа (D'Appolonia), Центро Свилуддо Материали (Centro Sviluppo Materiali), Эпиф ИАРЭЙ Технологи (Edif ERA Technology), Жи.И.Ти (G.E.T), Логмарин Эдвайзорс (Logmarin Advisors), ӨүЭсТи Энэржи (OST Energy), Поарис (Polaris), СиЭс Сэмбэнэли Консалтинг (SC Sembenelli Consulting), Ситек (Seatech) зэрэг олон улсад нэр хүндтэй хэд хэдэн компаниудыг нэгтгэсэн инженерингийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээний арвин их өв туршлагыг нэг дор цуглуулсан байгууллага юм.

<sup>3</sup> Давуу эрхтэй Зээлдүүлэгчдийн группэд Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК), Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ), Канадын экспортын хөгжлийн агентлаг (КЭХА), АНУ-ын Экспорт, импортын банк (АНУ ЭИБ), Экспортын санхүү, даатгалын корпораци (ЭСДК), Олон талын баталгаа гаргагч агентлаг (ОТБГА), Стандарт чартеред банк (СЧБ), БиЭнПи Парибас байгууллага орно.

<sup>4</sup> 2007 оны 4-р сард ОУСК-аас гаргасан БОЭМАА-ны удирдамжид Салбарын олон улсын тэргүүн туршлага (СОУТТ) гэдгийг “олон улсад ижил төстэй нөхцөлд, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй, туршлага, үр чадвар эзэмшсэн мэргэжилтнүүдэд зүй ёсоор тавигдах мэргэжлийн үр чадвар, хичээл зүтгэл, онц ухаан, алсыг харах чадвар...” гэж тодорхойлжээ.

<sup>5</sup> 2017 оны 5-р сарын “Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн хяналт шинжилгээний тайлан – 2017 оны 8-р сард уурхайд хийсэн аудитын тайлан”, баримт бичгийн дугаар 13-391-Н10, АрАЙЭНЭЙ консалтинг

Энэхүү тайланд цэвэр бохир усны менежментийн асуудлаас бусад, тухайлбал, Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө (ҮАМТ), Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ), Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ) болон бусад холбогдох баримт бичигт тусгасан Төслийн үүрэг амлалттай холбоотой илэрсэн зөрчлийг (3-р хэсэг дэх Төслийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийн хураангуйлсан хүснэгтийг үзэх) арилгах талаар ямар арга хэмжээ авч байгаа тухай мэдээллийг тусгав.

Баримт бичгийн хяналтад үндэслэн хийсэн энэ удаагийн аудитын тайланд онцолсон гол зүйлсийг дор товч хураангуйлав.



**Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоо**

Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоо нь төслийг удирдан явуулах, Төслийн стандартууд, Монгол Улсын хууль, дүрэм журам, тусгай зөвшөөрлийн нөхцөл, 2009 оны 10-р сарын 6-нд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ, ОУСК, ЕСБХБ-ны байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, нийгмийн бодлого, стандарт шаардлагуудыг хангах цогц тогтолцоо юм. Уг менежментийн систем болон холбогдох Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) нь тасралтгүй шинэчлэн сайжруулахад чиглэсэн төлөвлөх, үйл ажиллагаа явуулах, тайлагнах, хяналт тавих зэрэг үе шатуудаас бүрдэнэ. Тусгай/тодорхой үйл ажиллагааны төлөвлөгөөнд төслийн үүрэг амлалт, гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх параметр үзүүлэлтүүд, хэрэгжилтийг хангах холбогдох баримт бичгүүдийг тодорхойлдог. Үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг 2015, 2016 онуудад шинэчилсэн, харин БОНМТ-г 2017 оны сүүлээр шинэчлэх юм. Уг тогтолцооны бас нэг хэсэг нь Өөрчлөлтийн менежментийг хэрэгжүүлэх процесс бөгөөд энэ тайлангийн холбогдох хэсгүүдэд дурдсан төслийн төлөвлөгөө, үүрэг амлалтад засвар өөрчлөлт оруулах явцыг уг процессын дагуу удирдан явуулдаг. Зээлдүүлэгчид эдгээрийн ихэнхийг хүлээн зөвшөөрсөн.

**Цэвэр, бохир усны менежмент**

*Тэмдэглэл.*

*Усны нөөцтэй холбогдолтой сэдвүүдийг энэхүү баримт бичгийн аудитын шинжилгээний ажлын даалгавраас хассан. Ус, бохир усны менежментийн бие даасан тайлан 2017 оны 12-р сард боловсруулагдана. (БОНХЗ-ийн тайланг харна уу. Баримт бичгийн дугаар 13-391-Н12, хувилбар 0, 2018 оны 1-р сар)*

**Эрдсийн хаягдлын менежмент**

Ил уурхай, Хаягдал чулуулгийн овоолго (ХЧО), Хаягдал хадгалах байгууламж (ХХБ)–аас гарах эрдсийн хаягдлын менежментийг Төслийн стратегид заасны дагуу хэрэгжүүлж байна. Овоолсон хаягдал чулуулгийг Хүчил үүсгэх чадвартай (ХҮЧ-тай) материал, Хүчил үүсгэх чадваргүй (ХҮЧ-гүй) материал гэж ангилан ялгах, геотехникийн ExPit програмаар Эрдэс хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хяналт шинжилгээ хийх шаардлагатай. Гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил үргэлжилж байгаатай холбоотойгоор хаягдал чулуулгийг шинээр байгуулсан Хүчил үүсгэх чадвар (ХҮЧ)-тай материалд зориулсан хаягдал чулуулгийн нэгдсэн шинэ овоолго руу зөөвөрлөж байна. Өмнөд хаягдлын овоолгын зах хэсэгт ХЧО-ыг ургамалжуулах туршилтын төслийн хүрээнд ХҮЧ-гүй болон ХҮЧ-тай эрдэсийн хаягдлын хучилт хийх ажлыг гүйцэтгэсэн ба цаашид шимт хөрс, ургамлан давхаргыг байгуулах ажлуудыг тус туршилтын талбайд хийх юм.

Баяжуулах үйлдвэрээс гарах хаягдлыг ХХБ руу шахан зайлуулж, үйлдвэрийн/технологийн ус гаргаж авдаг. Одоогоор ХХБ-ийн 1-р бассейныг ашиглаж байна. 2018 онд үргэлжлэн хийгдэх хаягдал хуримтлуулахад зориулсан чулуун далангийн барилгын ажил 96 хувийн гүйцэтгэлтэй байна. Шахуургын станцыг ашиглан ХХБ дээр эргүүлэн татах усны менежментийг үр дүнтэй явуулсан. Геотехникийн нөхцөлийг тодорхойлох, авч үзэхэд хяналт чухал ач холбогдолтой учир ОТ хэмжилтийн багаж хэрэгсэл нэмэлтээр суурилуулж, ХХБ-ийн Барилгын ажил, ашиглалт, хяналт шинжилгээний гарын авлагыг шинэчлэн сайжруулсан. ХХБ-ийн зүүн хойд хэсгийн улнаас гарч буй шүүрэл нь байгууламжийн төлөвлөгөө, тооцооны дагуу байгаа бөгөөд хяналт шинжилгээ тогтмол хийж байгаа. Ус эргүүлэн татах цөөрөм болон шүүрсэн усан дахь ууссан хатуу бодисын нийт хэмжээ (УХБНХ), давсны агууламж өндөр байна. Зэрлэг амьтад орохоос хамгаалж шүүрлийн цөөрмийг тойруулан хашаа барьсан. ХХБ-ийн зураг төсөлд заасны дагуу шүүрсэн усыг хуримтлуулсны дараа ХХБ руу буцаан шахаж, Баяжуулах үйлдвэр рүү татна.

**Эрдсийн бус хаягдлын менежмент**

Үйлдвэрлэлийн явцад гаргаж байгаа бүх хог хаягдлын менежментийг Төсөл зуун хувь өөрийн хүчин чадлаар зохицуулж байна. Дахин боловсруулах хаягдал түр хадгалах төв (ДБХТХТ) хаягдал хадгалахаа бүрмөсөн зогсоосон ба орон нутгийн гэрээт компани 2017 оны 5-р сараас хойш Хаягдлын менежментийн төв (ХМТ) -ийг ажиллуулж хог хаягдлыг олон төрлөөр ангилан ялгаж, тусгай зориулалтын талбайд бетон, хуванцар пинд хадгалж байна. Хаягдлын гарцын хувьд, хамгийн сүүлд хийсэн тооцоогоор, одоо ашиглагдаж байгаа нэгдүгээр үүр 2018 оны эцэс гэхэд дүүрэхээр байгаа. Нэмэлт 2 ба 3 дугаар үүрийн инженерийн зураг төсөл хийгдэж байгаа бөгөөд барилгын ажлыг 2018 оны 2-р улиралд эхлүүлэхээр төлөвлөсөн. Шатаах зуухыг зогсоож оронд нь автоклавыг 2017 оны 10-р сард ашиглалтад оруулсан.

Сүүлийн аудитаас хойш 6 гэрээт компани хог хаягдлыг хуванцар, хаягдал металл, мод, техникийн тос зэрэг ангиллаар ялган дахин боловсруулалт хийн ажиллаж байгаа ба уурхайн талбайн хог хаягдлын дахин боловсруулалт эрс сайжирсан.

**Агаарын чанар**

Том ширхэгтэй хүдрийн овоолгын (ТШХО) байгууламжид их хэмжээний тоос үүсэж байдаг. Уг тоосыг бууруулах зорилгоор хөөсөөр тоос дарах систем (гадаргуун идэвхит бодисын систем) суурилуулсан. Ингэснээр ТШХО байгууламж доторх агаарт тогтсон нийт тоосны нягтрал (TSP) мэдэгдэхүйц багассан байна. Гэхдээ орчны агаар дахь бодисын хяналт шинжилгээний мэдээнээс үзэхэд төслийн стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн хэвээр байна. Өнгөрсөн жилд энэ чиглэлээр томоохон сайжруулалтуудыг хийсэн. Үүнд туузан дамжуургын төгсгөл хэсэгт канвас таг суурилуулах, нунтаглагч тээрмийн (ХӨН) буцах эргэлт дээрх материал буцалтыг багасгах зорилгоор шүүр тавих, цэвэрлэгээ хийх үеийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс дамжуургын дор хамгаалалтын тор тавих зэрэг ажлууд багтана. Ойрын хугацаанд ТШХО-ын байгууламжийн зүүн, урд, баруун хананд хөшиг/хаалт суурилуулахаар төлөвлөж байна. Үүнийг баяжуулах үйлдвэрт ашиглагддаг даралтат шүүлтүүрийн шүүлтүүр, резинэн дэвсгэрийг дахин ашиглаж хийнэ. Хөшиг/хаалтыг 2018 онд суурилуулах ба ингэснээр ТШХО-ын байгууламжийн доторх нарийн ширхэгт тооцонцор хийсэх бужигнахаас сэргийлэх хамгаалалт болно. Хөөсөөр тоос дарах олон арга хэлбэрийг туршиж үзсэн.

Түүнчлэн агаарын чанарыг сайжруулах шинэ сүлжээг байгуулж, ашиглалтад оруулав. Уг системийн үйл ажиллагаа одоо жигдэрсэн ба байнгын хяналт шинжилгээнээс авсан мэдээллийг дараа дараагийн БОНХУ-ний тайланд оруулна.

ДТС-ын утааны чанар Төслийн стандартад хүрэхгүй байгаа асуудал удаа дараа тавигдсаар ирсэн. Станцын утаанд хяналт шинжилгээ хийсэн хөндлөнгийн байгууллагын дүгнэлтээр утаанаас дээж авахад хэрэглэж байгаа аргачлалд хэд хэдэн дутагдалтай тал байгааг илрүүлсэн. Энэ мэдээлэл эргэлзээтэй байгаа учир 2018 онд Дулааны төв станцын хүчин чадлыг 130 мВт болгох 2 дахь шатны өргөтгөлийн ажлын хүрээнд Утааны тогтмол хяналт шинжилгээний систем (УТХШС)-ийг үндсэн янданд суурилуулна. Энэ нь АЧХШТ-ний байнгын хяналт шинжилгээ хийх шаардлагад нийцсэн ажил юм. Бүх бойлеруудад бүрэн засвар үйлчилгээ хийсэн, нийт 1,500 гаруй уутат шүүлтүүр сольсон зэрэг бусад сайжруулалтын ажлууд мөн ДТС-д хийгдсэн.

Шатаах зуухны утааны чанарын үзүүлэлт Төслийн стандартад хүрэхгүй байгаа асуудал урт хугацаанд үргэлжилж байна. Одоо шатаах зуухыг ашиглах шаардлагагүй болсон ба ашиглалтаас бүрэн гаргах үйл явц явагдаж байна. Сард 100 орчим кг гардаг эмнэлгийн хог хаягдлыг халдваргүйжүүлэх автоклавыг суурилуулсан. Тос арчсан даавуу материал зэрэг бусад аюултай хог хаягдлыг давхар шугам бүхий хаягдлын менежментийн төв болон дахин боловсруулалт хийх өөр аргуудаар зохицуулж байна

ОТ хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) хэмжээг бүртгэдэг бөгөөд 2016 онд нийт 1,429,619 CO<sub>2</sub> (eq) бүртгэгдсэн. Энэ нь 2015 онд бүртгэгдсэн 1,463,057 тонн CO<sub>2</sub>-тэй харьцуулахад харьцангуй тогтвортой үзүүлэлт юм. 2015 онд ялгаруулсан нүүрсхүчлийн хийн 80% нь 2-р хүрээнд хамаарах эх үүсвэрээс эрчим хүч худалдан авсантай холбоотойгоор 1,159,647 CO<sub>2</sub> (eq) бүртгэгдсэн. 1-р хүрээнд хамаарах шууд эх үүсвэрээс ялгарсан нүүрсхүчлийн хийн хэмжээ нь 269,972 CO<sub>2</sub> (eq) байсан бол 3-р хүрээнд хамаарах шууд бус эх үүсвэрээс үүссэн нүүрсхүчлийн хэмжээ маш бага байгаа юм. Өнөөгийн байдлаар 2017 оны (1-10-р сар хүртэлх) нийт ХХЯ 1,137,824 CO<sub>2</sub> (eq) байна.

Хөндлөнгийн байгууллагаас Оюу толгойн хүлэмжийн хийн ялгаруулалтад үнэлгээ хийсэн тайланг 2016 онд гаргасан. Уг тайланд ХХЯ-ын мэдээллийг Рио Тинтогийн Хүлэмжийн хий, эрчим хүчний хэрэглээний ажлын журналд заасан шаардлагын дагуу тодорхойлсон. Хүлэмжийн хийг 2016 онд гаргасан Рио Тинтогийн Хүлэмжийн хий, эрчим хүчний хэрэглээний ажлын журналд заасан аргачлалаар бүртгэдэг. Рио Тинтогийн хүлэмжийн хийн бүртгэл нь Дэлхийн тогтвортой хөгжлийн бизнесийн зөвлөл/Дэлхийн нөөцийн институтийн Хүлэмжийн хийн протоколд тусгасан тодорхойлолтуудад үндэслэсэн байдаг.

#### **Онцгой байдлын үеийн бэлэн байдал, авах арга хэмжээ**

Онцгой байдлын үеийн бэлэн байдал, авах арга хэмжээний төлөвлөгөө (ОБУББААХТ) дагуу өндөр болон ноцтой эрсдэл бүхий салбар/үйл ажиллагаанд гарч болзошгүй ослыг удирдах онцгой байдлын үед авах арга хэмжээний журмыг шинэчлэн боловсруулсан байна. Уурхайд бүхэлд нь болон тухайн ажлын талбар/хэлтэст учирч болзошгүй эрсдэлд чиглэсэн онцгой байдлын үед авах арга хэмжээний 15 журам боловсруулсан ба 2017 онд *Ханбумбат нисэх буудлын онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө*, *ХХБ-ын онцгой байдлын төлөвлөгөөг* шинэчлэн боловсруулсан. Онцгой байдлын баг, Орон нутгийн харилцааны баг хамтран холбогдох төрийн байгууллагын ажилтнуудыг ХХБ-тай танилцуулах ажлыг санаачилж, ХХБ-ийн Онцгой байдлын үед авах арга хэмжээний журмыг хувилан тарааж, ослын үед холбоо барих мэдээлэл, ХХБ-ийн ажилтнуудын мэдээллийг шинэчлэх журмыг шинэчлэн сайжруулсан байна. Нутгийн иргэдэд ХХБ, онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний талаар товч танилцуулахаар төлөвлөсөн байсныг тус төлөвлөгөөний хамрах талбайг өөрчлөхтэй холбогдуулан 2017 оны 5-р сард түр зогсоосон. ХХБ-ын онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний хамрах талбайг шинэчлэн тогтоох талаар судалгаа үнэлгээ, судалгаа хийгдэж эхлээгүй тул ХХБ-ын Орон нутаг,

оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөний шинэчлэлт, хэрэгжилтийг одоогийн ХХБ-ын ОБТ-ний дагуу үргэлжлүүлэн явуулах шаардлагатай болж байна.

Гүний уурхайн онцгой байдлын төлөвлөгөөг 2017 оны 6-р сард шинэчилж, Уул уурхайн яаманд хүргүүлсэн бөгөөд уг төлөвлөгөөнд 2017 оны сүүлийн хагас жилд хийгдэж байгаа гүний уурхайн бүтээн байгуулалттай холбоотой гол ажлуудыг тусгасан.

#### ***Тээврийн менежмент***

Тээврийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд танилцуулах сургалт, орон нутаг, байгаль орчны мэдлэг олгох сургалтын хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлж байгаагаас гадна SmartCar (операторт шууд тухайн цагт нь сэрэмжлүүлэг өгдөг), Readiband (нойрны хэмнэлийн талаар илүү ойлголттой болоход туслах) технологийг ашиглах зэргээр зэсийн баяжмал тээвэрлэж байгаа операторуудын алжаал ядаргаанд хяналт тавих, удирдах хөтөлбөрийг нэвтрүүлсэн. Эрүүл мэндэд эрсдэл учруулахаас сэргийлэх үүднээс алжаал ядаргааг хянах, удирдах тус хөтөлбөрийг Эрүүл мэндийн хэлтэстэй хамтран хэрэгжүүлж байна.

#### ***Экологийн менежмент, биологийн олон янз байдал***

Өмнөх аудитаар илэрсэн гурван зөрчлөөс хоёрыг энэхүү баримт бичгийн аудитын үед хаасан ба нэг зөрчил нээлттэй хэвээр үлдсэн. 2017 оны 8-р сард тоосжилтын хяналт-шинжилгээг эхлүүлснээр тоосжилтын хяналт-шинжилгээтэй холбоотой зөрчил хаагдсан. Ховор ургамлын зүйлийг амжилттай үржүүлэх төлөвлөгөө гаргасан тул уг асуудалтай холбоотой зөрчлийг хаасан. ОТ/Зээлдүүлэгчид Нөлөөлөл бууруулах стратегийн хүрээнд цаашид хийх ажлаа харилцан тохиролцоо (БОЯБҮАТ-ний дагуу) хүртэл Авто замын нөлөөллийг бууруулах стратегитай холбоотой зөрчил нээлттэй хэвээр үлдэж байна. Ховор ургамлын өөрчлөлт, ялангуяа Грубовын хөөндийн талаар шинэ зөрчил нэмэгдэхээс сэргийлэх үүднээс 2018 оны хаврын аудитаас өмнө хэрэгжүүлэх шаардлагатай хэд хэдэн санал зөвлөмжийг БОНХЗ өгсөн. Гэсэн хэдий ч ховор ургамалтай холбоотой (Грубовын хөөндий) зөрчил шинээр нэмэгдсэн.

#### ***Цахилгаан дамжуулах шугамтай холбоотой нөлөөллийг удирдан зохицуулах***

ОТ-н суурилуулсан тусгаарлагчийн үр дүнг үргэлжлүүлэн хянаж байна. Урьдчилсан үр дүнгээс харахад тусгаарлалтын төслийн үр дүнд шувуудын хоргодол багассан байна. ОТ-н эзэмшлийн бус шугамд нөлөөлөл бууруулах арга хэмжээ хэрэгжүүлсний дараа судалгаа хийхэд тусгаарлагч суурилуулсан өндөр хүчдэлийн шон мөргөж шувуудын тоо 0.25-аас 0.05-с болж багассан байна. 2017 онд ОТ-н эзэмшлийн цахилгаан дамжуулах шугамд үргэлжлүүлэн үнэлгээ хийхэд 11 цахилгааны шонд тусгаарлагч нэмж суурилуулах шаардлагатай (хэрэв эдгээр шонгуудыг шувууд мөргөж эрсдэх явдал байгаа нь хяналт шинжилгээний үр дүнгээр тогтоогдвол) болж болзошгүй.

Цахилгаан дамжуулах шугамд тусгаарлагч суурилуулах ажил нь цэвэр эерэг нөлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дүйцүүлэн хамгаалах 4 төслийн нэг юм. Туршилтын шатанд ОТ эрсдэлтэй, өөрийн эзэмшлийн бус 50 км урт цахилгаан дамжуулах шугамд тусгаарлагч нэмж суурилуулсан. 2018 онд “Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв” (ЗАСХТ)-тэй хийсэн гэрээний хүрээнд нэмж 300 км өөрийн эзэмшлийн бус, эрсдэлтэй шугамд тусгаарлагч суурилуулна.

2017 онд ОТ-н цахилгаан дамжуулах шугамын дагуу нийт 128 шувуу хүчдэл мөргөсний 115 нь монгол ногтруу, 2 нь жороо тоодог (ховор төрөл зүйл) байв. Орон нутгийн ТББ жороо тоодог судлах олон жилийн судалгааны төсөл эхлүүлсэн ба уг төслийн талбай нь ОТ төслийн талбайтай давхцаж байгаа юм. Энэхүү судалгаа нь Монгол улс дахь жороо тоодог хэмээх шувууны тоо толгой, амьдралын хэвшил, амьдрах орчны шаардлагын талаар ойлголтыг сайжруулах судалгаа болно гэж үзэж байна. ОТ-н зүгээс энэхүү судалгаанд ямар дэмжлэг үзүүлж болох талаар тус ТББ-тай хамтран ажиллана.

15 кв -ийн цахилгааны шугамын улсын стандарт боловсруулах ажил урьдчилсан тооцоогүй шалтгааны улмаас удааширсан ч 2018 онд төлөвлөсний дагуу ОТ-н дүйцүүлэн хамгааллын 4 төслийн нэг төслийн нэг хэсэг болж хэрэгжинэ. Уг стандартыг 2019 онд хэрэгжүүлж, хяналт-шинжилгээ хийнэ.

#### ***Оролцогч талуудтай хамтран ажиллах***

Өмнөх аудитаар ОТ дүйцүүлэн хамгаалах 4 төслийн хүрээнд тодорхой оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг тухайн хийх ажлын сэдвээс хамааруулсан хамтран ажиллах төлөвлөгөөг илүү нарийвчлан боловсруулах шаардлагатай нь тодорхой болсон. Өмнөх аудитын үеэр БОНХЗ-ийн зүгээс биологийн олон янз байдлын чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө (ОТХАТ) -ний F хавсралтын 1-р хүснэгтэд зарим нэг өөрчлөлт оруулах зөвлөмж өгсөн. Эдгээр өөрчлөлт нь оролцогч талуудын цаашдын ажлын стратеги төлөвлөлт, хуваарийг гаргах, дүйцүүлэн хамгаалах төсөл тус бүрийн зорилгыг тодорхойлох, бүртгэх, хянах, тайлагнах ажилд дэмжлэг үзүүлэх зорилготой. Эдгээр зөвлөмжийн ихэнхийг хэрэгжүүлсэн. ОТХАТ-д биологийн олон янз байдалтай холбоотой оролцоог ерөнхийд нь тодорхойлсон боловч дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах тухайлсан, тодорхой оролцоог нарийвчлан төлөвлөөгүй. Дүйцүүлэн хамгаалах 4 төсөлд талуудын оролцоо ямар

байхыг чиглэл бүрээр тодорхойлох эсвэл ОТ-н 2018 оны оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд талуудын оролцоог дэлгэрэнгүй төлөвлөх нь зүйтэй.

#### Экосистемийн үйлчилгээ

Сүүлийн аудитаас хойш экосистемийн үйлчилгээний талаар БОНХЗ-д мэдээлэл ирээгүй. Экосистемийн үйлчилгээний үнэлгээ, хяналт шинжилгээний төлөвлөгөө (ЭҮХШТ)-ний үр дүнг 2018 оны 1-р улиралд гаргах Жилийн тайланд оруулна. Дараагийн аудитаар уг төлөвлөгөөг үр дүнгийн хамт хянаж, зорилгод нийцэж байгаа эсэх, үзүүлэлт, хяналт шинжилгээний шалгуурыг өөрчлөх шаардлагатай эсэхийг тодорхойлох шаардлагатай.

#### **Газар хөндөлтөд хяналт тавих, нөхөн сэргээлт хийх**

##### Ховор ургамлын зүйлд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийх

Хэдийгээр ОТ ховор ургамлын төрөл зүйлүүдэд үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх хүчин чармайлт гарган, нөлөөлөл бууруулах арга хэмжээг шатлалын дагуу авч хэрэгжүүлж байгаа ч зарим бүлгэмдэл нөлөөлөлд өртсөн байна. а) ОТ-н цаашдын дэд бүтцийн байршлын шаардлага уурхайн лицензийн талбайд нутагшдаг Грубовын хөөндийн бүлгэмдэлд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх зорилготой зөрчилдөж байгаа, б) үржүүлэг, шилжүүлэн суулгах ажлын үр дүн гарахад удаан хугацаа шаарддаг с) зарим тохиолдолд Грубовын хөөндийд нөлөөлөх сөрөг нөлөөллөөс зайлсхийх аргагүй зэрэг шалтгаанаас үүдэн БОНХЗ үүнтэй холбоотой шинэ зөрчил үүсэхээс сэргийлэх хэд хэдэн зөвлөмж өгсөн.

ОТ ховор ургамал хамгаалах журам, ховор ургамалын талаар хийх судалгааны төлөвлөгөөг үргэжлүүлэн хэрэгжүүлнэ. Ховор ургамалд үзүүлэх нөлөөллийг багасгахын тулд газар хөндөх батлагдсан зөвшөөрөл, ховор ургамал хамгаалах журмыг үргэжлүүлэн ашиглана. Үржүүлгийн арга хэлбэрийг үргэжлүүлэн сайжруулна. Нөхөн сэргээлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад ховор ургамлын төрөл зүйлүүдийг нөхөн сэргээлтийн талбайд оруулж, тохирох амьдрах орчин, газрын бүтцийг бий болгох юм.

##### Техникийн нөхөн сэргээлт

ОТ техникийн нөхөн сэргээлтийн зорилтуудаа 2015, 2016 онд биелүүлж чадаагүй. Харин шимт хөрсийг сэргээх, солиход чиглэсэн бууруулсан анхан шатны техникийн нөхөн сэргээлт хийх амлалтаа биелүүлж байна. Нийт хөндөгдсөн газрын талбайн хэмжээ багасч байгаа ба Ханбогд-ОТ-н хатуу хучилттай замаас бусад хөндөгдсөн газрын 90 орчим хувьд нөхөн сэргээлт хийсэн. Зарим нөхөн сэргээсэн газрыг Засгийн газарт хүлээлгэн өгөхөд бэлэн болсон. Нөхөн сэргээлтийг уурхайн лицензийн талбайд, тухайн газрыг дахин ашиглахгүй болж чөлөөлөгдсөн үед хийж байна. Шимт хөрсний нөөцөөс болон салхиар дамжиж өөрөө үрслэн ургах байгалийн ургамалжилтын байдлыг ажигласны үндсэн дээр нэмэлт үрсэлгээ (биологийн нөхөн сэргээлт) шаардлагатай эсэхийг ОТ шийдвэрлэнэ. Ямар тохиолдолд байгалийн ургамалжилт хангалттай эсвэл хангалтгүйд тооцогдох талаар системтэй аргачлалтай байх шаардлага тавигдаж байна.

##### Биологийн нөхөн сэргээлт

ОТ 2017 оны 3-р улирлын байдлаар нийт 7.45 га талбайд (уурхайн талбайн дотор болон гадна) техникийн нөхөн сэргээлт хийсэн. 53.85 га талбайд хуурай үрсэлгээ, устай үрсэлгээ хийх замаар биологийн нөхөн сэргээлт хийсэн ба үүний 27 га газарт шинээр нөхөн сэргээлт хийж, 27 га газарт хөрвөх менежмент хэрэглэсэн. 2016 онд хийгдэх ёстой байсан нөхөн сэргээлтийн ажил гэрээт компанийн гүйцэтгэлийн асуудлаас болж хийгдээгүй ба тус компани тавьсан шаардлагыг биелүүлснээр (заримыг давуулан биелүүлсэн) 2017 онд энэ асуудал шийдэгдсэн. Технологийн нөхөн сэргээлт хийгдсэн газруудад үр дүн сайн гарна гэж таамаглаж байна.

##### Ховор ургамал үржүүлэх

2017 оны 5-р сард хийгдсэн Зээлдүүлэгчийн аудитаар ховор ургамалтай холбоотой зөрчил илрүүлсэн. Энэ зөрчлөөр ОТ-д бүх төрлийн ховор ургамлын үржүүлгийн судалгааны цогц хөтөлбөр боловсруулах шаардлага тавигдсан.

Энэхүү зөрчил болон ховор ургамлын төрөл зүйлийн талаар Зээлдүүлэгчдийн санаа зовниж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор ОТ урт богино хугацааны төлөвлөгөө боловсруулж, Нутгийн ургамлын үржүүлгийн төвийн ховор ургамлын төрөл зүйлийг үржүүлэх чадамжийг сайжруулах улмаар нөхөн сэргээлтийн тариалалтад ховор ургамлын төрөл зүйлийг оруулах чиглэлээр тодорхой үйл ажиллагаануудыг багтаасан хөтөлбөр боловсруулсан. Ховор ургамлын судалгаа нь нутгийн ургамлын үржүүлгийн төвд ургуулахгүй байгаа Грубовын хөөндий (*Spongiocarpella grubovii*), хулан хойрго (*Potaninia mongolica*, потаниний хотир (*Zygophyllum potaninii*) гэсэн 3 төрлийн ховор ургамлыг эхний ээлжинд авч үзнэ.

Нутгийн ургамлын үржүүлгийн төвийг 2017 оны 7-р сараас эхлэн Экоминерал компани удирдан ажиллуулж байна. Экоминерал компани зарим төрлийн ховор ургамлын үрийг цуглуулж, үрийн соёололтын туршилт

хийсэн. Өнгөрсөн 6-9-р сард хийгдсэн сүүлийн аудитаас хойш нийт 2408 төрлийн ургамалыг НУУТ-д шилжүүлэн байршуулсан ба энэ нь үйл ажиллагаа төлөвлөгөөнд багтсан ажил юм. Ховор ургамлын үржүүлгийн техникийн судалгааны ажил үргэлжилж байна.

Энэ асуудлыг шийдвэрлэх талаар нэлээд ахиц гарч байна гэж БОНХЗ үзэж байна. Үржүүлгийн аргыг боловсронгуй болгоход чиглэсэн судалгааны тхетөлбөрийг 2018-2020 онд хэрэгжүүлэхээр боловсруулсан бөгөөд ОТ цаашид ч ховор ургамлын төрөл зүйлийг нөхөн сэргээлтэд амжилттай хамруулахын тулд амьдрах орчны шаардлагуудын талаар мэдлэг мэдээллээ нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Түүнчлэн ОТ Монгол улсын их сургуулийн судлаачидтай нөхөн сэргээлтийн дараах хяналт шинжилгээний чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөж байна. Эхний жилийн хяналт шинжилгээний үр дүн 2018 оны 3-р сард бэлэн болно.

Энэ аудитаар уг зөрчлийг хаав.

#### Бор Овоогийн булаг

Бор-Овоогийн булгийн орчимд Экоминерал компанийн хийсэн ургамалжуулалтын эхний туршилтын үр дүн хангалтгүй байсан тул 2017 онд дахин хийсэн (Бор-Овоогийн булаг орчмын 2 га хашаалсан газарт). 2017 оны 9-р сард Экоминерал, ОТ-н Ургамал судлалын багийн хамтарсан хэсгийн тогтоосноор таримал суулгацын амьдрах чадвар дөнгөж 13%, 4 төрөл зүйлийн суулгац огт амьдраагүй байна. Энэ нь гэрээт компани суулгацыг тарьсан жилдээ усалгааг багадуулснаас болсон байх магадлалтай. ОТ Бор-Овоогийн булгийн ургамалжилтын байдалд Биологийн нөхөн сэргээлтийн журмын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу дараагийн 3-5 жилд хяналт-шинжилгээг үргэлжлүүлэн хийнэ.

#### Хаягдал чулуулгын овоолгыг ургамалжуулах туршилт

Сүүлийн аудитаас хойш ХЧО-ын ургамалжуулалтын ажилд зарим ахиц гарсан. Хүчил үүсгэх чадвартай чулуулгийг чулуулгийн янз бүрийн түвшний гүнд, хүчил үүсгэх чадваргүй чулуулгийг дөрвөн өөр төрлийн овоолгын дээр хүчил үүсгэх чадваргүй давхаргад байрлуулсан. Шимт хөрсийг өвлийн улиралд, тоног төхөөрөмжийн боломж гарсан үед байрлуулна. Үр суулгалтыг 2018 оны хавар устай үрсэлгээ, хуурай үрсэлгээний аргын аль нэгийг ашиглан хийнэ гэж 2017 оны 11 сарын аудитын үеэр БОНХЗ-д мэдээлсэн.

#### **Замын хөдөлгөөн, тээвэртэй холбоотой нөлөөллийг удирдах**

2017 оны 5-р сараас хойш ОТ-н замтай холбоотой замын хөдөлгөөнд өртсөн зэрлэг амьтад, осол аваар гараагүй. 2016 оны 12-р сард гарсан хулангийн амь эрсэдсэн ослын дараа Ургамал судлалын багийн мэргэжилтнүүд нэг ээлжийн 100 орчим жолоочийг хамруулсан сургалт зохион байгуулж ОТ-н УЛП-н ойр орчмын зэрлэг амьтад учирч болзошгүй эрсдлүүд, тэдгээрээр хэрхэн сэргийлэх талаар хэлэлцсэн. Бусад ээлжийн ажилчдыг хамруулах төлөвлөгөөг логистикийн багтай хэлэлцэж байна.

Радио төхөөрөмж суулгасан хулангийн хөдөлгөөний GPS мэдээлэл ОТ- ГШ замын нөлөөлөл, саадын талаар шийдвэр гаргах хэмжээний баримт мэдээлэл болж чадахгүй байна. Иймд ОТ хулангийн замаас дайжих байдлын талаар судалгаа хийхээр Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгтэй зөвшилцсөн. Хулангийн шилжилт хөдөлгөөний мэдээлэлд хийсэн дүн шинжилгээг 2017 оны 12-р сард гарах Биологийн олон янз байдлын хяналт шинжилгээний төлөвлөгөөнд оруулна.

ОТ-н Замын нөлөөллийг бууруулах стратегитай холбоотой техникийн асуудлуудад хараат бус дүгнэлт гаргах, санал зөвлөмж өгөх зорилгоор ОТ Замын нөлөөллийг бууруулах стратегийн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) байгуулсан. Зөвлөлийн тайланд ОТ-ГШ чиглэлийн зам өмнөд говийн бүс нутагт орших цагаан зээр, хулангийн тоо толгойд материаллаг эрсдэл учруулахгүй байна гэж дүгнэсэн.

100 орчим км замд цагаан зээр, хулан зэрэг нүүдэллэдэг амьтдын замаас дайжиж байгаа байдалд хийсэн хяналт шинжилгээний үр дүн тодорхой үр дүн харуулаагүй. Замын нөлөөллийг бууруулах хяналтын зөвлөл болон зөвлөхүүдийн төхөөрөмж суулгасан амьтдаас авсан мэдээлэлд үндэслэсэн дүгнэлтэд зэрлэг амьтад замаас дайжихаас илүү малаас дайждаг гэж дүгнэсэн байна.

Нийт туурайтан амьтдын шилжилт хөдөлгөөний хувьд нүүдэллэхэд учирч байгаа саад бэрхшээл төрөл зүйл бүрийн хувьд янз бүр байгаа тул нөлөөлөл бууруулах стратеги үүнийг анхаарч үзэх нь зүйтэй. Өргөн уудам нутагт тархсан тоо толгойн хувьд хэсэг газрын нөлөөллийг тодорхойлох нь хүндрэлтэй гэдгийг Зөвлөл хүлээн зөвшөөрсөн тул ОТ энэ асуудлыг мэдээлэл цуглуулах өнөөгийн аргачлалдаа хэрхэн тусгах талаар судалж байна. Зөвлөлөөс ОТ-н зүгээс эдгээр төрөл зүйлүүдэд эерэг нөлөө ахиу үзүүлэхэд хувь нэмэр оруулах хамгийн зөв арга бол биологийн төрөл зүйлийн дүйцүүлэн хамгааллын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх явдал ба энэхүү хөтөлбөр нь ОТ-ГШ зам бус харин бэлчээрийн нөөц бүхий газруудад анхаарал хандуулж, Өмнийн говийн нутаг дэвсгэрт урт хугацаанд хуримтлагдсан сөрөг нөлөөллийг багасгах улмаар хөтөлбөрийн үр дүнд олж авах шинжлэх ухааны мэдлэгийг уг хүчин чармайлтыг бэхжүүлэн дэмжих явдал гэж зөвлөсөн.

Нийт туурайтан амьтдын шилжилт хөдөлгөөний хувьд нүүдэллэхэд учирч байгаа саад бэрхшээл төрөл зүйл бүрийн хувьд янз бүр байгаа тул нөлөөлөл бууруулах стратегид үүнийг анхаарч үзэх нь зүйтэй. Өргөн уудам нутагт тархсан тоо толгойн хувьд хэсэг газрын нөлөөллийг тодорхойлох нь хүндрэлтэй гэдгийг Зөвлөл хүлээн зөвшөөрсөн тул ОТ энэ асуудлыг мэдээлэл цуглуулах өнөөгийн аргачлалдаа хэрхэн тусгах талаар судалж байна.

Түүнчлэн устаж болзошгүй эрсдэл өндөртэй, судлагдсан байдал хомс гэсэн шалтгаанаар хар сүүлт зээрийг судлах тал дээр илүү анхаарал хандуулахыг зөвлөсөн. Биологийн олон янз байдлын хяналт шинжилгээний 2018 оны төлөвлөгөөнд хар сүүлт зээрэнд GPS төхөөрөмж суулгах ажил төлөвлөгдсөн.

Санал болгосон өөрчлөлтийг бодитоор хэрэгжүүлэхийн өмнө зэрлэг амьтдын хяналт шинжилгээний ажилд шууд оролцоотой байгууллагуудтай зөвлөлдөж, тэдний зөвлөмжийг тайлангийн дүгнэлт зөвлөмждөө оруулахыг Зөвлөл санал болгосон. ОТ, Састэнэбилити Ийст Эйжиа болон Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн ажилтнуудтай 2017 оны 10-р сарын 31-нд зөвлөмжийн сүүлийн хувилбарыг хэлэлцэх уулзалт хийсэн. Түүнчлэн автозамын нөлөөллийг бууруулах стратегийг 2017 оны 4-р улиралд багтаан шинэчлэн боловсруулахтай холбогдуулан Зээлдүүлэгчдийн төлөөлөгчдийн санал зөвлөмжийг авах уулзалт хийсэн.

ОТ, Зээлдүүлэгч Нөлөөлөл бууруулах стратегийн хүрээнд цаашид хийх ажлаа харилцан тохиролцох (БОЯБҮАТ-ний дагуу) хүртэл Авто замын нөлөөллийг бууруулах стратегитай холбоотой зөрчил нээлттэй хэвээр үлдэж байна.

Гэхдээ энэ зөрчлийн шийдвэрлэх явц ахицтай байгаа тул II -р ангиллаас I ангилал руу бууруулсан.

ОТ дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд энэ хөтөлбөрийн зарим хэсэг нь зөвхөн төрөл зүйлийн хуваагдлыг бууруулахад (төмөр замын хашааг буулгах г.м) чиглэсэн бол зарим хэсэг нь (хулгайн ан агнуурын эсрэг, ноолуурын үйлдвэрлэлийн тогтвортой хөгжил гм) бусад цогц асуудлуудад чиглэсэн. ОТ нь Говийн бүсэд хуримтлагдсан нөлөөллийг бууруулах чиглэлээр өөрийн судалгаа шинжилгээний мэдээллээр дэмжлэг үзүүлэхийг зорьдог. Ийм ч учраас 2018 оны хавар Даланзадгадад зохион байгуулагдах биологийн олон янз байдлын чуулга уулзалтыг ивээн тэтгэж оролцохоор төлөвлөж байгаа ба энэхүү чуулганд судлаач, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллүүд хамтран, биологийн олон янз байдлын асуудлууд, энэ чиглэлээр хийгдсэн судалгаа шинжилгээний талаар хэлэлцүүлэг өрнүүлэх юм.

ОТ- ГС-ын хатуу хучилттай замын ажил 2017 оны сүүлийн хагаст үргэлжлэн явагдаж байгаа ба аюулгүй ажиллагааны асуудлуудыг шийдвэрлэсэн. Замын ажлын үе шат бүр ОТ-н Газар хөндөх зөвшөөрлийн дагуу явагдсан ба нөлөөлөл бууруулах зохих ёсны арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Замын асуудлаар орон нутгийн ард иргэд төр засгийн янз бүрийн түвшний байгууллагуудтай тогмтол санал солилцдог.

## Бохирдлын нөлөөллийг удирдах

### Тоосжилтын хяналт-шинжилгээ

Өмнөх аудитаас хойш тоосжилтийн хяналт-шинжилгээнд зарим ахиц гарсан. 8-р сард профессор Болдгив болон түүний багтай ургамлын байнгын хяналт шинжилгээний 32 талбайд тоосжилтын хяналт шинжилгээ хийх гэрээ байгуулсан. Тоосжилтын бэлчээрт нөлөөлөх нөлөөллийг судлах судалгааны аргачлалыг боловсруулж судалгааны талбайг 2 чиглэлийн дагуу сонгосон. Хээрийн судалгааг 2017 оны 9-р сард хийж дуусгасан. Энэ судалгааны үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг 2017 оны 4-р улиралд өгөх гэрээт гүйцэтгэгчдийн тайланд оруулна.

Энэ ажил явагдаж байгаа тул уг зөрчлийг хаав.

### Селен

Сүүлийн аудитаас хойш ХХБ-ын селений түвшин зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа тул ХХБ-ын ойр орчмын шувуудад ажиглалтын мэдээлэл цуглуулаагүй. Амьтны аймгийн судалгааны баг ХХБ-ын үйл ажиллагааны багтай хамтран ХХБ-д ажиллах, аюулгүй үеийг тааруулан үнэлгээ хийнэ. ОТ уг үнэлгээг шувуудын нүүдлийн оргил үеийг тохиолдуулан хийхээр төлөвлөж байна. Амьтны аймгийн судалгааны багийн гишүүдийг ХХБ-д ажиллах бэлтгэлийг ханган, танилцуулах сургалтад хамруулна.

Биологийн олон янз байдлын популяцид сөрөг нөлөө үзүүлсэн тохиолдол өмнөх аудитаас хойш гараагүй байна.

### Эерэг нөлөө ахиу үзүүлэх, дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө

ОТ Эерэг нөлөө ахиу үзүүлэх урьдчилсан тооцоо болон Дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу биологийн олон янз байдалд үлдэх нөлөөллийг бууруулахад чиглэсэн ажлууд хэрэгжүүлэх, улмаар Өмнийн говийн биологийн олон янз байдалд эерэг нөлөө ахиу үзүүлэхэд дэмжлэг болох ажлуудыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Аудит хийх үед ОТ-н биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах дөрвөн төслийн ахиц явцын талаар мэдээлэл өгсөн.

**Хулгайн ангийн эсрэг арга хэмжээ:** Зуны турш хулгайн ангийн эсрэг ямар нэг үйл ажиллагаа явагдаагүй тул сүүлийн аудитаас хойш энэ талаар мэдээлэх зүйл байхгүй.

**Ноолуур үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх санаачилга :** малчдад сургалт явуулсан, хоточ ноходтой болсон зэрэг хэд хэдэн үйл ажиллагаа хэрэгжсэн: малчдын сургалт, хамгаалалтын ноходтой болсон зэрэг хэд хэдэн үйл ажиллагаа хэрэгжсэн.

**Цахилгаан дамжуулах шугамд нэмэлт тусгаалагч суурилуулах төсөл:** мэдээллийг дээр оруулсан.

**Төмөр замын хашааг буулгах:** Сүүлийн аудитаас хойш энэ төсөлд тодорхой ахиц гарсан. Састэнэбилити Ийст Эйжиа/ Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгтэй 8-р сард гэрээг эцэслэн байгуулсан. Зам тээврийн сайдын зөвшөөрлийн бичиг шаардлагатай байсан хэдий ч 2017 оны 9-р сард Засгийн газар, Ерөнхий сайд солигдсонтой холбоотой уг бичиг гараагүй. Шинэ Засгийн газар саяхан эмхлэгдэн байгуулагдсан тул Састэнэбилити, Зэрлэг амьтдыг хамгаалах сан шинэ сайдтай зөвшөөрөл авах талаар холбогдоно. Хашаанд хаалга гаргах, эсвэл хашааг өөрчлөх зэрэг ажлуудыг 2018 оны 1- улиралд эхлүүлэх төлөвтэй байгаа хэдий ч яамны зөвшөөрлийг хэзээ хүлээн авах, төмөр замын удирдах газрын багийн ажлын хуваарь, цаг агаарын нөхцөл байдал зэргээс шалтгаалж хугацаа нь шийдэгдэнэ.

### Хяналт шинжилгээ, хөрвөх менежмент

2017 оны биологийн олон янз байдлын хяналт шинжилгээний үр дүнд дүнд анализ хийх ажил явагдаж байгаа бөгөөд 2017 оны тайлан 11-р сарын эцсээр бэлэн болох төлөвлөгөөтэй байна. Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн өгсөн урьдчилсан мэдээллээс харахад хяналт шинжилгээний аль нэг босгоос давж гарсан үзүүлэлт байхгүй байна. Энэхүү урьдчилсан мэдээллийн зарим хэсгийг багтаасан тайланг Байгаль орчны яаманд өгсөн. Хулангийн шилжилт хөдөлгөөний хяналт шинжилгээг 14 бодгальд үргэлжлүүлэн хийснээс гадна үхсэн амьтны сэг зэмд хяналт шинжилгээ хийж байна. Бэлчээрийн амьдрах орчны чанарын үнэлгээний хэмжигдэхүүн боловсруулах ажил 2017 онд үргэлжилсэн.

### Хүний нөөц, ажиллах хүч

Ургамал, амьтан судлалын багийн ажилтнуудын тоонд өөрчлөлт гараагүй, харин зарим ажилтнууд Улаанбаатар хот руу шилжсэн. Зарим шилжилт хөдөлгөөнд дахин үнэлгээ хийсэн. Өмнөх аудитын үед ихэнх ажлыг гаднаас гүйцэтгүүлж байсан тул БОНХЗ-ны байгуулсан амьтан судлалын багийн бүрэлдэхүүн хангалттай байсан. Ургамлын судлалын багийн ажилд Экоминералс баг 2017 оны 6 сараас эхлэн ажилласан дэмжлэг үзүүлж байна.

ОТ Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг, Биологийн олон янз байдлыг хамгаалах олон улсын холбоо зэрэг байгууллагуудаас зөвлөх, мэргэжилтнүүд авч ажиллуулж байна. Экоминералс компанитай хамтран ажиллах 3 жилийн гэрээг 2017 оны 7-р сарын 7-ны өдөр байгуулсан ОТ-н мэргэжилтнүүдийн хяналт, зөвлөхүүдийн менежмент нь цөлийн орчинд эерэг нөлөө ахиу үзүүлэх үүрэг амлалтыг амжилттай биелүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн хэвээр байх болно. Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгтэй биологийн олон янз байдлын үндсэн хяналт шинжилгээний чиглэлээр хамтарч ажиллах гэрээ 2020 он хүртэл үргэлжилнэ. Биологийн олон янз байдлыг хамгаалах олон улсын холбоо ОТ-д техникийн туслалцааг газар дээр нь үзүүлж ирсэн. БИБХОУН-ны гэрээ 2017 оны 12-р сард дуусч байгаа тул нээлттэй тендер зарлана. Шинэ гэрээт байгууллагатай 2018 оны 1-р сараас эхлэн биологийн олон янз байдлын дэмжлэг авах гэрээ байгуулж ажиллана. Экоминералс компани нутгийн ургамлын үржүүлгийн төвийн үйл ажиллагаа болон хашаа хайс, ургамалжуулалтын үрсэлгээ, байгалийн ургамал, тэр дундаа ховор ургамлын үр цуглуулах ажлыг хариуцан гүйцэтгэдэг. Энэ аудитын явцад БОНХЗ-д мэдээлснээр тус компани төлөвлөсөн бүх ажлаа гүйцэтгэсэн байна.

## Нийгэм

### Хөдөлмөр эрхлэлт, ажлын нөхцөл

2017 оны 9-р сарын 30-ны байдлаар ОТ уурхайн талбай болон Улаанбаатар хот, Өмнөговь аймгийн Ханбогд суманд үндсэн ажилтнууд болон гэрээт компанийн ажилтнуудыг оруулаад (гүний уурхайн ажилчдыг оролцуулан) нийт 12,845 ажилчид байна. Ажиллах хүчний бүтцийн хувьд Хөрөнгө оруулалтын гэрээнд заасны дагуу буюу 93.85% нь монгол ажилчид байна. Тэднээс 2880 нь Өмнөговь аймгийн ажилчид байгаагийн 55.9 хувь нь Ханбогд сумын, 29.8 хувь нь Даланзадгад сумын иргэд байна. Одоогийн байдлаар монгол удирдах ажилтнуудын чадавхи сайжрахын хэрээр гүний уурхайгаас бусад хэсгүүдэд гадаад ажилтнуудыг багасгах ажил үргэлжлэн явагдаж байна. ОТ-н ажилтан ажилд авах, сонгон шалгаруулах журмыг хянах ажил 2017 оны 7-р сард дууссан ба уг хяналтаар ОТ-н бизнесийн өнөөгийн байдал болон Өмнөговь аймагт ажлын байр бий болгох зорилтыг онцгойлон авч үзсэн.

Ажилтнуудыг шилжүүлэх стратеги болох Рөүз төсөл үргэлжлэн хэрэгжиж уурхайн талбайд зайлшгүй байрлаж ажиллах шаардлагагүй ажлын байруудыг Улаанбаатар, Даланзадгад, Ханбогд руу шилжүүлсэн. 2017 онд нийт 240 ажлын байрыг шилжүүлсэн ба 2018 онд нэмж 60 ажлын байрыг шилжүүлэх төлөвтэй байна. Үүнтэй холбоотой МТ/технологийн шийдлүүд хүлээгдэж байна. Ажлын байрыг шилжүүлсэн нь ажилчдын ажил амралтын тэнцвэрт байдал сайжирсан гэж тэд эерэгээр дүгнэснээс гадна гадна уурхайн талбайн байрны эрэлтийг багасгахад нөлөөлсөн.

Өмнөговь аймгийн иргэдийн ур чадварын судалгааг үргэлжлүүлэн шинэчилж 1,126 иргэний ур чадварын судалгааг (гэрээт ажилчдын оруулан) ОТ болон Өмнөговь аймгийн хөдөлмөрийн албанд өгөөд байна. Энэхүү бүртгэл судалгааг ашиглан 2017 оны 6-10 дугаар саруудад ОТ-н гэрээт гүйцэтгэгчид Өмнөговь аймгийн 141 иргэнийг ажлын байраар хангасан. Ханбогд суманд байрлан ажиллаж байгаа хүний нөөцийн ажилтан хүсэлт гаргасан аймгийн иргэдийн мэдээллийг бүртгэх, ОТ болон гэрээт компаниудад санал болгох, ажил горилочдод ажлын ярилцлагад орохын өмнө дэмжлэг үзүүлэх зэрэг үйлчилгээ үзүүлж байна.

ОТ, Өвөр Монголын Өөртөө Засах Орон хоорондын хамтын ажиллагааны хүрээнд төлөөлөгчийн газар байгуулахаар ажиллаж байгаа ба Урадын төлөөлөгчийн газрын менежерийн томилгоо, шилжүүлгийн ажил хүлээгдэж байна. Эрсдэлийн үнэлгээ нь Өвөр монголын талаас холбогдох зөвшөөрлийг авах ажлуудаас гадна Урадад явуулах үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах нэмэлт арга хэмжээг тодорхойлох ажлаар хязгаарлагдсан.

ОТ Спийкаут гомдол санал хүлээн авах системд тайланийн хугацаанд 48 гомдол ирсэн. Эдгээр гомдлын 54 хувь нь нэрээ нууцалсан гомдлоор бүртгэгдсэн. Нийт ирүүлсэн гомдлын ангилалаар авч үзэхэд дийлэнх нь хувийн чанартай, чухал ач холбогдолгүй гомдол эзэлж байгаа дараа нь бизнесийн ёс зүйн асуудал орсон байна. Одоогийн байдлаар 3 гомдол шийдвэрлэгдээгүй үлдсэн ба судалгааны шатандаа явж байна.

Ажилчдын хөдөлмөрийн харилцаатай холбоотой хөндлөнгийн аудит, хяналт шалгалт үргэлжлэн явагдаж байгаагаас гадна МХЕГ-аас хийсэн шалгалтаар “хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх комисс байгуулах” шаардлага тавьсан. Энэхүү комиссыг байгуулах шаардлага Монгол Улсын хөдөлмөрийн хуулийн дагуу үүссэн бөгөөд ОТ уг комиссыг байгуулснаар Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжийг баримтлан ажиллаж байна. Гадаадын иргэн харьяатын газар болон МХЕГ-аас хөгжлийн бэрхшээлтэй ажилчдын нөхцөл байдлын талаар хийсэн шалгалтын үр дүн тодорхойгүй байна. Мөн 2 хяналт шалгалтын үр дүн энэ аудитын үеэр хараахан гараагүй байгаа.

ОТ гэрээт гүйцэтгэгчдийн хөдөлмөрийн харилцаанд үргэлжлүүлэн хяналт шалгалт хийж байгаа ба гэрээт гүйцэтгэгчдийн гарган өгдөг сар бүрийн мэдээлэл, ханган нийлүүлэгчдийн тайлангаас харахад энэ чиглэлээр системчлэгдсэн, сайжруулах үйл явц хэрэгжиж байна. Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө (ХМТ), цалин хөлсний судалгааг 12 гол гэрээт гүйцэтгэгч компанид явуулсан ба одоогоор 2 нь хянагдаж



байна. ХМТ-ний аудитыг 8 гэрээт компанид хийж гүйцэтгэсэн ба нэмж 7-д хийхээр төлөвлөсөн. Засан сайжруулах 2 арга хэмжээг биелүүлж дууссан, 4 нь үргэлжилж байна.

“Хамтдаа”, “Жишиг соёл” хөтөлбөрүүд нь ОТ, РТ төдийгүй гүний уурхайн төсөлд ажиллаж буй гэрээт болон туслан гүйцэтгэгчдийн төслийг цаг хугацаанд нь, батлагдсан төсвийн хүрээнд, аюул осолгүй хэрэгжүүлэх нийтлэг соёлд сургах үндсэн механизм болон үргэлжлэн хэрэгжиж байна. Өнөөг хүртэл 747 удирдах ажилтан, 2607 ажилтан сургалт семинарт хамрагдсан бөгөөд Coaching хөтөлбөрийг боловсруулж байна.

Уурхайн талбайн орон байрны өргөтгөлийн ажил хийгдэж байгаа ба Оюут-2 кэмийн барилгын ажил удаашралтай хэдий ч үргэлжилж байна. Энэхүү кэмийн эхний ээлжийн өрөөнүүд бэлэн болсон ба шинэ хэсгүүдийг нээхээс өмнө байгууламжийн ашиглалтын туршилт хийх ажил хүлээгдэж байна. ОТ 2018 оны 5-р сар гэхэд нийт 5,508 өрөөг бүрэн ашиглалтад оруулахаар зорьж байна. Энэ хүртэл одоогийн байгаа кэмпүүд дээр нэмж Оюут -2 кэмийн ашиглах боломжтой өрөөнүүдийг ашиглан уурхайн талбайн ажиллаж хүчийг орон сууцаар хангах юм. Аудит хийгдэх үед уурхайн талбайд нийт 5,500 ажилтан байрлаж байв. Үүний зэрэгцээ гал тогоо болон ус цэвэршүүлэх байгууламжийн чадамжийг нэмэгдүүлсэн. ОТ-н мэдээлснээр Зуны кэмп (ОТ-Гашуун сухайтын зам барилгын ажилчдын), Гашуунсухайтын замын кэмпээс бусад ОТ уурхайн бүх орон сууцны байгууламж хэвийн ажиллаж байна.

#### Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, амьжиргаа сайжруулах

Өмнөх аудитаар илэрсэн шийдвэрлэгдээгүй зөрчил нь Үр дүнгийн үнэлгээг гүйцээн хийхтэй холбоотой. Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн малчин өрхүүдэд хийх үр дүнгийн үнэлгээг ОТ-н шууд хяналт дор дахин хийхээр болсон. Орон нутгийн болон олон улсын түншүүдээс бүрдсэн зөвлөх баг томилогдож, мэдээлэлд судалгаа хийж байна. Судалгааны үр дүн 11, 12-р сард хийгдэх хээрийн судалгааны дараа буюу 2017 оны 12-р сард бэлэн болно. М1.23 үл нийцэл нь үр дүнгийн үнэлгээг амжилттай хийж дуустал нээлттэй хэвээр үлдэнэ.

ОТ-н замын арчилгаа үйлчилгээний ажил хийж гүйцэтгэсэн ажилтнуудын хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосон ба эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн малчин өрхийн 92 гишүүдэд зориулан Тогтвортой амьжиргааг дэмжих сургалтын хөтөлбөр боловсруулсан. Уг сургалтын хөтөлбөр нөхөн төлбөр авсан иргэдийн мал аж ахуйгаа тогтвортой эрхлэх, амьжиргаагаа удирдах чадварыг нэмэгдүүлэх зорилготой. Нийт 11 сарын хугацаанд явагдаж байгаа тэнхимийн болон дадлагын сургалт Дорнодын Политехникийн Коллежийн дэмжлэгтэйгээр 2017 оны 12-р сар хүртэл үргэлжилнэ. Тогтвортой амьжиргааг дэмжих сургалтын хөтөлбөрийн жил тутмын хяналт шинжилгээний тайлангаар эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан малчдын амьжиргаа хэрхэн дээшилж байгааг болон сургалтад хамрагдагсдын сэтгэл ханамжийн байдлыг тодорхойлно.

Бэлчээр, амьжиргаа сайжруулах менежментийн төлөвлөгөө (БАСМТ) -г эцэслэн боловсруулж ОТ-н цахим хуудсанд байршуулсан. Үүний зэрэгцээ БАСМТ-ний хэрэгжилтийг дэмжих зорилгоор Говийн Оюу Хөгжлийг дэмжих сан (ХДС)-гийн 3 жилийн стратегийг боловсруулах сэдэвчилсэн семинарыг сум орон нутаг, ТББ-ууд, малчид, усны менежмент, малын эрүүл мэнд, мал эмнэлгийн мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулж байна. Хөгжлийг дэмжих сангийн 320 сая төгрөгийн санхүүжилт бүхий “Бэлчээрийн үнэлгээ” төслийг 4 суманд хэрэгжүүлж байна. Энэ төсөл нь бэлчээрийн даац, багийн түвшинд боловсруулагдаж байгаа бэлчээрийн хэрэглээний төлөвлөгөөний талаархи үнэлгээ дүгнэлт өгөх юм. Мал аж ахуйн хөтөлбөр ч мөн үргэлжлэн хэрэгжиж байгаагийн зэрэгцээ малчин өрхүүдийг дэмжих хоршоо, жижиг бизнесийг олон үйл ажиллагаа хэрэгжиж байна.

Эмзэг бүлгийн өрхүүдэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжиж байгаа бөгөөд энэ аудитын үеэр 80 хувийн биелэлттэй байна. Энэхүү төлөвлөгөөнд бүлэг, өрхүүдийг дэмжих арга хэмжээнүүдийг багтаасан, эмзэг бүлгийн өрхүүдэд чиглэсэн үйл ажиллагааг хагас жилээр төлөвлөдөг. Түүнчлэн ХДС-ийн санхүүжилтийг засварын төв болон эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг дэмждэг хүүхэд хөгжлийн төвд зарцуулсан. Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд эмзэг бүлгийн өрхүүдэд үзүүлэх дэмжлэгийг зогсоох хүртэл ОТ-н зүгээс дээр дурдсан арга хэмжээнүүдийг үр дүнг үргэлжлүүлэн хянах шаардлагатай юм.

#### Оролцогч талуудтай хамтран ажиллах

Тодорхой сонирхлын бүлгүүдийн оролцоотой оролцогч талуудын хамтын ажиллагааны хүрээнд багийн хуралд оролцох, эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан өрхүүд болон ХХБ-аас доош, Цагаан хадны боомт хүртэл нутагладаг өрхүүдийн асуудал зэрэг үйл ажиллагаа багтсан. Тайлант хугацаанд Ханбогд сумын иргэдийн хөгжлийн төвөөр 1,402 иргэн үйлчлүүлж 172 хүн уурхайн үйл ажиллагаатай танилцах аялалд хамрагдсан байна. ОТ-н дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан Даланзадгад, Манлай сумын наадмын арга хэмжээнд 1,600 гаруй хүн хамрагдаж, Ханбогд сумын ахмадын өдрийн арга хэмжээнд 230 ахмадууд оролцсон. Эдгээр арга хэмжээний үеэр 2,200 ширхэг сар тутмын орон нутгийн сонин, улирал тутмын үйл ажиллагааны мэдээлэл болон цахим сонинг түгээжээ.

Хамтын ажиллагааны бүртгэл тэмдэглэлийг ОНХНХ баг үргэлжлүүлэн хийж оролцогч талын хамтын ажиллагааны хандлага, хариу арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж байна. 2017 оны 5-10-р сар хүртэл хугацаанд нийт хамтын ажиллагааны 141 үйл ажиллагааг хэрэгжүүлж, 15 үйл ажиллагаа үргэлжлэн хэрэгжиж байна. Өмнөх аудитаас хойш ОНХНХ багийн хийсэн үнэлгээгээр сөрөг хандлага төвийг сахисан эсвэл эерэг болж өөрчлөгдсөн бага зэргийн өөрчлөлт ажиглагдсан. Хамтын ажиллагааны хэлбэрийн хувьд ихэнх нь (156-аас 113 нь) зөвлөгөө өгөх хэлбэртэй байсан бол удаах хэлбэр нь мэдээлэл өгөх уулзалт (36) байсан аж. Мөн ОНХНХ баг хамтын ажиллагааны түвшинд ОТ-н олон нийтийг чадавхижуулах зорилгын дагуу үнэлгээ хийдэг. Өмнөх аудитаас хойш ОТ-н олон нийтийг чадавхижуулах зорилтын үнэлгээнд 2 онооны ахиц гарсан. “Ханбогодод тавтай морил” арга хэмжээнд 200 гаруй хүн оролцсон ба оролцогчдын 89 хувь нь уг арга хэмжээнд сэтгэл хангалуун байна гэж үнэлсэн байна. Эдгээр үр дүн болон ОНХНХ багийн орон нутгийн олон нийттэй хамтран ажиллах системийг сайшаах нь зүйтэй юм.

ОТ-н орон нутгийн санал гомдол шийдвэрлэх журмыг 2017 оны 4-р сараас шинэчлэн мөрдөж байна. Аудитын хугацаанд хүлээн авсан гомдлын тоо цөөн байсан ба хамгийн сүүлд 8-р сард 1 гомдол, нийт 6 гомдол ирснийг шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд шийдвэрлэгдсэн гомдлын мөрөөр ямар нэгэн санал хүсэлт ирээгүй. Орон нутгийн оролцогч талуудаас 46 хүсэлт ирсний 91 хувийг шийдвэрлэж, хаасан байна. Эдгээр хүсэлтүүдээс хамгийн нийтлэг гурван төрлийн хүсэлт нь хандив хүссэн, худалдан авалтын тухай болон хүний нөөц сургалттай холбоотой хүсэлтүүд байв. Энэ нь ОТ-н талаарх орон нутгийн иргэдийн мэдлэг, үндэслэлтэй хүсэлтийг хүлээн авдаг гэсэн итгэлийг харуулж байгаа юм.

Өмнөх аудитын үеэр хууль дүрмийн хэрэгжилтийн газар, гурван талт зөвлөлийн оролцогч талууд үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, нөхөн олговрын өргөдлийн хорооны үйл явцын талаар харилцан тохиролцоонд хүрсэн. Энэхүү тохиролцсон үйл ажиллагаанаас 12 нь хэрэгжиж нөхөн олговрын өргөдлийн хороо 4 удаа хуралдаж малчдын гомдлыг хэлэлцсэн. Эдгээр гомдлыг шийдвэрлэх ямар нэгэн тохиролцоонд хүрээгүй байна.

Байгаль орчны хамтын оролцоотой хяналт шинжилгээ (БОХОХШ)-ний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлыг 2017 оны 11-р сард дуусгах ба энэ ажлын хүрээнд ОТ-н өмнөөс хариуцан гүйцэтгэх ТББ-ыг шинээр байгуулах юм. Энэхүү ТББ-д байгаль орчны чиглэлээр сургууль төгссөн 5 шинэ төгсөгчийг бүтэн цагаар ажиллуулах ба малчид ус, бэлчээр, тоосжилт, Ундай гол гэсэн 5 чиглэлээр байгаль орчны хяналт шинжилгээний мэдээлэл цуглуулна. ОТ-н зүгээс ТББ-д ажиллах шинэ төгсөгчдийн ур чадварыг дээшлүүлэх, БОХОХШ-ий хөтөлбөрийн амжилтыг үнэлэх шалгуур үзүүлэлтийн боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллана.

#### Бүс, орон нутгийн хөгжил

Бүс, орон нутгийн хөгжил нь ОНХНХ багийн гол үүргийн нэг бөгөөд голдуу Өмнөговь аймагтай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээгээр дамжин хэрэгждэг. Энэ үйл ажиллагааг ОТ хөгжлийг дэмжих сангаар дамжуулан санхүүжүүлж, Харилцааны хороо, ХДС-ийн ТУЗ-аас удирдан, орон нутгийн хамтын ажиллагааны хэлбэрээр хэрэгжүүлдэг. Сүүлийн аудитаас хойш ХДС-ийн эхний жилийн тайлан хэвлэгдсэн ба тус сан үйл ажиллагаа явуулсан 2 жилийн хугацаанд 62 төсөл хэрэгжүүлэхэд 10.9 сая ам. доллар зарцуулжээ. Аудитын хамрах хугацаанд ХДС-ийн дараагийн 3 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажил явагдаж байгаа ба ХДС-ийн ТУЗ-ын зүгээс жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх 3 жилийн төлөвлөгөөг баталсан.

2017 оны 10-р сард хийсэн ХДС-ийн ТУЗ-ын хурлаар 3.2 сая долларын өртөгтэй 15 шинэ төсөл, хөтөлбөрийн санал дэмжигдсэн. Эдгээр төслүүдийн талаар ТУЗ-д техникийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Ус, байгаль орчны дэд комисс байгуулагдсан.

ХДС-ийн үйл ажиллагаа, санхүүжилтэд хийх хөндлөнгийн үнэлгээ 2017 оны 11-р сард хийгдэнэ. Мөн хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг ХДС -ийн үйл ажиллагаа болон төсөл хэрэгжүүлэх түвшинд боловсруулахаар төлөвлөсөн. Энэхүү төлөвлөгөө нь ОТ, хамтран ажиллагч байгууллагуудад зорьсон үр дүндээ хүрсэн эсэхийг тодорхойлох, ОТ-н нөлөөлд өртсөн өрхүүд ХДС-ийн хөрөнгө оруулалтаас ямар хэмжээний ашиг тус хүртэж байгааг тодорхойлох боломжийг олгоход чухал ач холбогдолтой юм.

Тайлант хугацаанд “Ирээдүй хойч үе сан (ХДС-ийн санхүүжилтийн 5%) -гаас 57 оюутанд 151 сая төгрөгийн тэтгэлэг олгосны зэрэгцээ тус бүр 30 хүртэлх сая төгрөгийн сан бүхий ЖДҮ-г дэмжих 11 зээлийг олгосон байна. Тэтгэлэг авсан оюутнууд амжилттай суралцаж байгаагаас гадна зээлийн төлөлт хэвийн явагдаж байгааг ОТ мэдээлсэн. Аудитын хамрах хугацаанд 415 сая төгрөгийн хандив тусламжийг олгосон (ХДС-ийн санхүүжилтийн 2%) ба 77 сая төгрөгийн хандив тусламжийг олгохоор шийдвэрлээд байна. Хандив тусламжийг соёлын арга хэмжээ зохион байгуулах, байгалийн гамшгаас сэргийлэх, малчдын хадлан тэжээл бэлтгэхэд зориулсан байна.

Орон нутгийн дэд бүтцийн төслүүд үргэлжилж байна. Ханбогд сумын дэд бүтцийн төслүүд 2017-2018 онд хэрэгжиж дуусах ба үүнд ОТ-Ханбогдын зам (2018 оны 4-р улиралд багтаан дуусгах зорилготой), ХДС-ийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа хатуу хог хаядлыг булаах төсөл (2017 оны 4-р улирал), бойлерийн

байгууламжийн барилгын төсөл (2017 оны 4-р улирал), сургууль цэцэрлэгийн барилгын ажил (2017 оны 3-р улирал) орно.

ОТ-н санхүүжилттэй ОТ- Гашуунсухайтын замын төслийн санхүүжилтийг батлах, гүйцэтгэгчийг шалгаруулах ажил хүлээгдэж байна. 2018 оны 1-р сард эхлэх барилгын ажлын худалдан авалтыг урьдчилан төлөвлөсөн ба ажилчдын татан авалтыг 2018 оны 2-р сард хийнэ. Монгол улсын хил хамгаалах ерөнхий газраас кэмгийн барилга барих газрын зөвшөөрөл олгосон. Тухайн асуудлаар хамтран ажиллах төлөвлөгөөг ажиллах хүч татахаас өмнө өвөл урьдчилан боловсруулах ба кэмгийн үйл ажиллагааг ОТ, Хил хамгаалах газар хамтран хянах юм. Уг төслийг 2018 оны 3-р улиралд багтаан дуусгахаар төлөвлөсөн.

Хүн амын шилжин ирэх хөдөлгөөний төлөвлөгөө (ХАШИХМТ)-г ОТ баталж, олон нийтэд ил болгосон. Хүн амын шилжин ирэх хөдөлгөөнийг зохицуулах үйл ажиллагааны хэрэгжилт нь хөндлөнгийн Харилцааны хороогоор дамжуулж хэрэгждэгээрээ Төлөвлөгөөнөөс ялгаатай. Харилцааны хороо нь ОТ, Өмнөговь аймгийн тамгын газар, сумын тамгын газрын төлөөлөөс бүрддэг бөгөөд бүх талуудын хүчин чармайлтыг оновчтой зохицуулахыг эрмэлздэг. Харилцааны хорооны хоёр дахь удаагийн уулзалт 2017 оны 10-р сард зохион байгуулагдсан.

Тус хороо дараах 5 ажлын хэсэгт санал зөвлөмж өгдөг. Үүнд: орон нутгийн худалдан авалтын ажлын хэсэг, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэсэг, стратегийн уялдаа холбоог хангах ажлын хэсэг, Ханбогд сумыг хөгжүүлэх ажлын хэсэг, Хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх ажлын хэсэг болон ХДС, Харилцааны хорооны ажлын хэсэг. Ажлын хэсгүүд нь Харилцааны хороонд тайлагнах асуудлаар шийдвэр гаргах эрхтэй. Өмнөговийн стратегийг 2017 оны 4-р улиралд Харилцааны хороотой хамтран боловсруулах бөгөөд Ханбогд сумыг хөгжүүлэх ажлын хэсэг хүн амын шилжин ирэх хөдөлгөөнийг зохицуулах, бууруулах тодорхой ажлууд хийхээр төлөвлөж байна.

Орон нутгийн ажил эрхлэлт, худалдан авалтын ажлуудыг ХАШИХМТ-тэй уялдуулан хийнэ. Орон нутгийн ажил эрхлэлтийн ажлын хэсэг орон нутгийн иргэн гэсэн тодорхойлолтыг “Өмнөговь аймагт 3 ба түүнээс дээш жил байнга оршин сууж байгаа иргэнийг хэлнэ” гэж өөрчлөхөөр тогтсон. 2017 оны 9-р сарын 30-ны байдлаар ОТ-н ажилчдын 20 хувийг Өмнөговь аймгийн иргэд бүрдүүлж байна. Орон нутгийн худалдан авалтын ажлын хэсэг орон нутгийн аж ахуйн нэгж гэсэн тодорхойлолтыг “Өмнөговь аймагт бүртгэлтэй; байнгын ажиллах хүчнийх нь 75-аас доошгүй хувийг монгол ажилчид бүрдүүлдэг; Монгол ажилчид нь Өмнөговь аймагт байнга оршин суудаг; Өмнөговь аймагт салбартай” аж ахуйн нэгжийг” хэлнэ гэж тодорхойлохоор тогтсон. Орон нутгийн худалдан авалт 14 төрлийн бараа үйлчилгээг худалдан авдаг ба өнөөдрийн байдлаар 62 сая ам долларын орон нутгийн худалдан авалт хийгээд байна.

#### **Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа**

Эрүүл мэндийн баг нь ЭМААБОАБОН-ийн хэлтэст харьяалагддаг төвлөрсөн нэгж бөгөөд хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээ, олон улсын SOS эмнэлгийн үйлчилгээг хамааруулан ажилладаг. Ажлын байран дахь эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээнд өндөр эрсдэлтэй хэсэгт ажилладаг ажилтнуудын дуу чимээ, тоос, тоосонцор, силикос, гагнуурын очид өртөх өртөлтийн хэмжээнд анхаарч ажилладаг. Дизелийн тоосонцорын асуудал гүний уурхайн үндсэн эрсдэлүүдийн нэг болоод байгаагийн дээр тоног төхөөрөмжүүдийн ажиллагааг, засвар үйлчилгээний хэрэгцээг тодорхойлоход ач холбогдол өгч байна. Үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээ авахаас гадна ажилтнуудад эрүүл мэндийн эрсдэлийн талаарх ойлголт мэдлэгийг нь дээшлүүлэх сургалтууд явуулж байна. Эрүүл мэнд, сайн сайхан амьдралыг дэмжих санаачлагын хүрээнд Эрүүл мэндийн баг ахлах ажилтнуудад зориулсан 6 сарын сургалтын хөтөлбөрийг эхлүүлсэн ба олон улсын SOS эмнэлгийн ажилтнуудад сургалт явуулж, нэмэлт эмч мэргэжилтнүүдийг авч ажиллуулсан.

Гүний уурхайн төсөлтэй холбоотой уурхайн талбайн ажиллах хүчний тоог нэмэгдүүлсэнтэй уялдуулан ОТ-н Аюулгүй байдлын хэлтсээс компанийн үйл ажиллагааг Рио Тинтогийн шинэ гаргасан стандартуудад нийцүүлэх, кэмгийн аюулгүй ажиллагааг хангахад чиглэсэн нэмэлт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Уурхайн ажилтнуудад учирч болох 17 ноцтой эрсдэлд онцгойлон анхаарч, ноцтой эрсдэлийн хяналтын магадлагаа хийх зорилготой. Ноцтой эрсдэлийн удирдлага хөтөлбөрийг уурхай даяар хэрэгжүүлж, гүний уурхайн үйл ажиллагаа болон гэрээт компаниудын үйл ажиллагаанд нэвтрүүлээ. Химийн бодис алдагдах, гал гарах, дэлбэрэлт үүсэх, бусад аюул осол зэрэг үйлдвэрийн үйл ажиллагааны системээс үүдэлтэй болзошгүй аюул эрсдэлийг авч үзэх Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны менежментийн системийг Баяжуулах үйлдвэр, Төв дулааны станц, Максам тэсэлгээний байгууламжид нэвтрүүлсэн. Ил уурхай, Хаягдал хадгалах байгууламж, Экспортын тээвэрлэлтийн хэлтсүүдийн тээврийн автомашины операторуудын алжаал ядаргааг удирдах, мөн хэд хэдэн хэлтэст хамаарах гараар гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай ажил үүргийг тодорхойлж, сайжруулах төлөвлөгөө боловсруулах зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа талаар Эрүүл мэндийн хэлтэс онцлон тэмдэглэсэн.

#### **Нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал**

Хаягдал хадгалах байгууламжтай холбоотойгоор орон нутгийн иргэдийн оролцоо, ялангуяа ХХБ-д гэмтэл гарсан тохиолдолд авах арга хэмжээ нь ХХБ-ны онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөний онцгой бүрэлдэхүүн хэсэг юм. ОТ-ны ОНХНХ баг орон нутгийн оролцогч талуудын жагсаалтыг шинэчилсэн ба улирал тутмын хээрийн хяналтыг зун хийж гүйцэтгэсэн. Осолд өртөж болзошгүй хэсэгт айл өрх, иргэд шинээр нүүж ирсэн тул (барилгын ажлын 2,3 багийн ажилчдыг оруулан) онцгой байдлын үед авах арга хэмжээний журмыг шинэчилж нөлөөлөлд өртөж болзошгүй хүмүүсийн нэр, холбоо барих дугаар зэргийг оруулаад байна. Осолд өртөж болзошгүй талбайг эцэслэн тогтоогоогүй байгаа нь ОНХНХ багийн нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн иргэдтэй үр дүнтэй хамтран ажиллах боломжийг хязгаарлаж байна. ОНХНХ баг Цагаан хадны хилийн зурвас хүртэлх газрыг хяналтдаа байлгахын зэрэгцээ онцгой байдал хариуцсан төрийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

Аудитын хугацаанд орон нутгийн иргэдтэй холбоотой ямар нэг аюул осол, аюулгүй ажиллагааны асуудал гараагүй ба ОНХНХ баг сумын цагдаагийн хэлтэстэй хамтарч гэмт хэргийн мэдээлэл статистикийн хяналтыг үргэлжлүүлж байна. Ханбогд суманд гарсан гэмт хэргийн 80 хувь нь Хайрхан багийн нутаг дэсвэрт, нүүрсний тээвэрлэлттэй холбоотой гарсан байна. Хэдийгээр Цагаан хадны хилийн боомт ОТ-н хариуцах асуудал ч гэсэн энэ хэсэг, ялангуяа ОТ-ГС чиглэлийн зам барих барилгын ажилчдын кэмп хилийн зурвастай ойрхон байгуулагдахтай холбоотойгоор орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал хөндөгдөнө. Иймд ОТ- ГШ чиглэлийн зам барилгын ажлы гүйцэтгэхэд чиглэсэн ОТХАТ-г тусгайлан боловсруулж Хил хамгаалах газар, Ханбогд сумын цагдаагийн хэлтэс, Урадын Өвөр монголын өөртөө засах орны засаг захиргааны байгууллага хамтран аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал байнгын хяналт тавьж тодорхой нөхцөл байдалд авах хариу арга хэмжээнд бэлэн байх шаардлагатай.

ХДС-ийн санхүүжилт нь олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны олон хөтөлбөрүүдэд чиглэгдсэн ба түүний дотор сургуулийн хамтын ажиллагаа, Эрүүл Малчин хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ахмад настны эрүүл мэндийн оношилгоо эмчилгээнд зарцуулагдсан байна. “Чадварлаг эмч” эмч нарын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжиж байгаагийн зэрэгцээ Говийн бүсэд анх удаа бүсийн нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээг хэрэгжүүлж байна.

ХХБ-ийн онцгой байдлын журамд улирлын чанартай суурьшдаг нөлөөнд өртөж болзошгүй малчин өрхийн (өөрөөр хэлбэл осолд өртөж болзошгүй бүсэд өвөлжөөтэй айлууд) бүртгэлийг тусгаж өгсөн. ХХБ-ийн Нутгийн иргэд, оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг 2017 оны сүүлээр эцэслэн гаргах бөгөөд үүнд ослын бэлэн байдал хангах арга хэмжээ, болон ОТ-н ослын үед хариу арга хэмжээ авах хөтөлбөрийн талаар хамрагдах бүсийн орон нутгийн холбогдох албаны хүмүүс болоод ослын нөлөөлөлд өртөх иргэд, оршин суугчдад мэдлэг мэдээлэл өгөх алхмуудыг тусгасан. БОНХЗ дараагийн аудитаар өрхүүдийн мэдээллийг авч холбогдох хамтын ажиллагааны арга хэмжээнүүдийн талаар дэлгэрэнгүй хэлэлцэнэ гэж төлөвлөж байна.

#### **Соёлын өвийн менежмент**

Соёлын өвийн хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн иргэдэд мэдээлэл өгөх, соёлын өвийг сурталчлан таниулах нийт 1,202 удаагийн сургалт уулзалт зохион байгуулсан байна. Аудитын хугацаанд соёлын өвтэй холбоотой ямар нэг зөрчил бүртгэгдээгүй. 2017 онд 64 газар хөндөх зөвшөөрөл олгосон ба ОТ-н ёс заншлын гэрт 1,018 зочин үйлчлүүлжээ. Соёлын өвийн хяналт-шинжилгээг 14 газарт үргэжлүүлэн хийж байна.

ХДС-ийн зүгээс хэд хэдэн соёлын өвийн хөтөлбөрийг дэмжин ажилладаг. Соёлын өвийг хамгаалах, аялал жуулчлалыг дэмжих хөтөлбөрийг Шар Цавын үлэг гүрвэлийн мөр бүхий газар болон Хүрдэт агуйд хэрэгжүүлж байна. Энэ чиглэлээр хийгдэж байгаа ажлын үр дүнг тэмдэглэсэн төслийн оролцогч талуудыг оролцуулсан арга хэмжээг 2017 оны 10-р сард зохион байгуулсан. Түүнчлэн ХДС-ийн санхүүжилт Ахмадын холбоо, бага сургуулийн хэрэгжүүлж буй Ханбогд сумын соёлын өвийн төслүүдэд дэмжлэг үзүүлж байна.

## 2 УДИРТГАЛ

Оюу толгой төсөл нь (цаашид “Төсөл” буюу “ОТ Төсөл” гэх) Монгол улсын өмнийн говийн бүс нутаг Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт, нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт ойролцоогоор 600 км, Монгол-Хятадын хилээс хойд зүгт 80 км-т оршдог. Тус ашигт малтмалын ордыг 2001 онд нээж илрүүлсэн бөгөөд зэс, алт, мөнгө, бага хэмжээний молибден агуулсан хэд хэдэн бүлэг ордоос бүрдэнэ. Тус төсөл нь Ил уурхай, Гүний уурхайг хамрах бөгөөд Баяжуулах үйлдвэр өдөрт 100,000 тонн баяжмал боловсруулан гаргаж, жилд 500,000 гаруй тонн баяжмал үйлдвэрлэнэ гэж тооцоолж байна. 2013 оны 7-р сараас хэрэглэгч нартаа бүтээгдэхүүнээ тээвэрлэн хүргэж эхэлсэн.

2013 оны 9-р сард “Оюу толгой” ХХК (цаашид “Төслийн компани” буюу ОТ гэнэ) өөрийн хэрэгжүүлж буй Оюу толгой төслийн (Монгол улс засгийн газар, Рио Тинто групп (цаашид РТ гэнэ), Туркуойз Хилл Ресурс компани хоорондын стратегийн түншлэл) Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөхөөр (БОНХЗ)<sup>6</sup> Итали улсын Генуя хотод байрладаг Д'Апполониа ХК (2017 оны 6-р сарын 5-с эхлэн АрАЙЭНЭЙ Консалтинг болсон)-ийг ажиллуулахаар гэрээ байгуулсан. 2012 оноос эхлэн РТ групп нь төслийн бүх хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдыг төлөөлөн төслийн менежментийг хариуцахаар томилогдсон.

АрАЙЭНЭЙ Консалтинг компани БОНХЗ-ийн хувьд санхүүжүүлэгч байгууллагуудад зориулан 2013 оны 9-р сарын 1-нд эхэлсэн ОТ уурхайн ашиглалтын (Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин) ЭМААБО, нийгмийн чиглэлд гол анхаарлаа хандуулан хөндлөнгийн үнэлгээ хийж гүйцэтгэх үүрэгтэй. БОНХЗ нь уг үүргийнхээ хүрээнд ОТ төсөл Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөөндөө тусгасан байгаль орчин, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлж байгаа эсэхийг санхүүжүүлэгч байгууллагуудад тайлагнах бөгөөд уг төлөвлөгөө нь БОННУ болон бусад холбогдох бичиг баримтад тодорхойлсон нөлөөллийг бууруулах стратегийг ОТ компани хэрхэн хэрэгжүүлэхийг заасан баримт бичиг юм. Эдгээр нь ирээдүйд тодорхой цаг хугацаатай гүйцэтгэх үйл ажиллагааны жагсаалт, мөн БОНХЗ төслийн Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны (БОНЭМАА) гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийхдээ ашигласан лавлагаа баримт бичиг болсон Ашиглалтын БОНМТ-үүдийг агуулсан төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ), Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (БОНУАТ) болно.

Энэхүү тайланд БОНХЗ-ийн 2017 оны 10-р сард хийсэн баримт бичгийн шинжилгээнд тулгуурлан хийсэн аудит, мөн хугацаанд Оюу толгой уурхайн талбайн ажилтнуудтай хийсэн теле-хэлэлцүүлгийн үр дүнг дэлгэрэнгүй тусгасан. Тайланд Төслийн өнөөгийн байдлыг үндсэн үзүүлэлтээр харуулж өмнөх БОНХЗ-ийн тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгах талаар авсан арга хэмжээний мэдээллийг оруулсан. Энэ тайлангийн мэдээллийг баримт бичгийн шинжилгээ, олон нийтийн хүртээл болгосон судалгаа, тухайлсан илтгэл танилцуулгууд болон ОТ-н ажилтнуудтай хийсэн ярилцлагын мэдээллүүдэд үндэслэн боловсруулсан. Түүнчлэн, 2017 оны 12-р сард усны бие даасан аудит хийгдэхээр төлөвлөгдсөн тул энэхүү аудитад усны нөөцийн холбогдолтой сэдвүүдийг оруулаагүй. Энэ тайланд дурдагдаагүй сэдвүүдийг 2018 оны 2-р улиралд уурхайн талбайд ажиллах БОНХЗ-ийн дараагийн ажлын үеэр авч үзнэ. Энэ үеэр БОНХЗ-ийн баг бүрэн бүрэлдэхүүнээрээ уурхайн талбайд ажиллахаар төлөвлөж байна.

Дараах тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

- ОТ компанийн өгсөн ЭМААБО, нийгмийн баримт бичиг, төсөлтэй холбоотой бусад баримт бичгийг судлах
- ЭМААБО, нийгмийн чиглэлийн дүрэм, журмын биелэлтийг хариуцсан багуудтай 2017 оны 10-р сарын 26-наас 11-р сарын 10-ны хооронд утсаар ярилцлага хийж, холбогдох төлөвлөгөө, дүрэм журамтай танилцсан.
- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө болон БОНМХ-т тодорхойлсон үүрэг хариуцлагын хэрэгжилт, биелэлтэд үнэлгээ хийх;
- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө болон БОНМХ-т тодорхойлсон үүрэг хариуцлагаас гажсан буюу аль эсвэл зөрүүтэй, дутагдалтай зүйл байгаа эсэхийг тодорхойлж, Салбарын олон улсын тэргүүн туршлагад (СОУТТ) үндэслэн БОЭМАА-г сайжруулах чиглэлээр зөвлөмж өгөх;
- БОНХЗ-ийн 2017 оны 8-р сард хийсэн Аудитын тайланд<sup>7</sup> тодорхойлсон дүгнэлт, ажиглалтын мөрөөр гүйцэтгэлийг хянаж, арилсан зөрчлийг хаах.
- БОНХЗ-ийн тайланг (энэ тайлан) боловсруулж, олон нийтийн хүртээл болгох.

Энэхүү тайланд дурдсан мэдээлэл, ажиглалт, үзэл бодол нь АрАЙЭНЭЙ Консалтинг компанийнх бөгөөд тэдгээр нь Төсөл болон/эсвэл давуу эрхтэй Зээлдүүлэгчдээс хараат бус, бие даасан болно. Тайланд дурдагдаагүй сэдвүүдийн тухайд ямар нэг эрсдэлтэй зүйл төслийн хүрээнд илрээгүй болно.

### 3 ТӨСЛИЙН ТОЙМ

#### 3.1 БАРИЛГА, АШИГЛАЛТЫН ЯВЦ

Уг төсөл нь зэс, алт, мөнгө, молибдены хэд хэдэн ордоос бүрдэх ба далд болон ил уурхайн арга техникийг хослуулан олборлодог. Төслийн ашиглалтын хугацаа нь Баттай ба Бодитой нөөцөд суурилснаар 40 жил (2016 оноос хойш) байна. Өмнөд Оюу орд болон Хюго Даммит орд нь хамтдаа 25.4 сая тонн зэс, 81,600 тонн молибден, ойролцоогоор 5,150 тонн мөнгө, 1,000 тонн алтны нөөцтэй гэж одоогийн байдлаар тогтоогоод байна. Өмнөд Оюу ордод зэс, алтны Ил уурхай, мөн Гүний уурхай (Хюго Даммит орд) байгуулж олборлолт хийхээр төлөвлөж байна. Баяжуулах үйлдвэрийн анхны зураг төслийн дагуу жилд 35 сая тонн түүхий хүдэр олборлох тооцоонд үндэслэн боловсруулагдсан (нэрлэсэн хүчин чадал нь өдөрт 100,000 тонн) ба жилд 500,000 гаруй тонн баяжмал боловсруулж гаргана гэж тооцоолж байна.

Ил уурхайгаас 2012 оны 2-р улиралд хоногт 24 цаг тасралтгүй энгийн хүнд даацын машин болон экскаватор ашиглан олборлож эхэлсэн. Тус уурхай нь ил уурхайн дотор талын налуу, хэвгийг тогтворжуулахын тулд чулуугаар хашиж тэсэлгээ хийсэн хэд хэдэн мөргөцгөөс бүрдэх ба хүдэр болон хаягдал шороо, чулууг хүнд даацын машинаар зөөхийн тулд тээврийн зам гаргасан байна.

Гүний уурхайг блокчлон олборлох аргаар олборлохоор төлөвлөж байгаа ба хүдрийн дор тулгуур үлдээн малтлага хийснээр хүдэр нь хүндийн хүчний үйлчлэлээр малтлага хийсэн хоосон орон зай руу өөрөө нурж орох замаар олборлоно. Гүний уурхайгаар олборлох арга нь үр ашигтай, өртөг зардал багатайгаас гадна хаягдал шороо чулуу бага гардаг, том хэмжээний хүдрийн биет олборлох боломжтой юм.

Хүдрийг баяжмалд хувиргах процессын загварыг энгийн бутлах, хөвүүлэн баяжуулах технологи болон батлагдаж туршигдсан тоног төхөөрөмж ашиглахад үндэслэн гаргасан. Тус процесст том бутлагдсан хүдрийг овоолж, анхдагч бутлуураар бутлах үйл ажиллагаа орно. Анхдагч бутлуураар буталсан хүдрийг 2.7 км урт газрын гадаргуу дээрх туузан дамжуулагчаар баяжуулах үйлдвэрийн ойролцоо байрлах овоолго руу хүргэж, тэндээсээ хүдрийг жижигсгэн бутлах том диаметртай цувраа тээрэм рүү шилжүүлнэ. Хөвүүлэн баяжуулах систем нь зэс агуулсан материалыг дараагийн үе шатанд боловсруулахаар шүүн авах ба флотацын том бассейн дотор шаардлага хангахгүй эрдсийг үнэ цэнэтэй хүдрээс ялгаж авдаг. Энэ зуур лагийг (хаягдал) хоёр өтгөрүүлэгчид 60% хатуу болгож өтгөрүүлээд, Хаягдал хадгалах байгууламжид (ХХБ) шахаж зайлуулдаг. Хаягдал өтгөрүүлэгч болон ХХБ-аас гарсан усыг баяжмал үйлдвэрлэхэд дахин ашиглана. Үүний дараа зэс, алт агуулсан эцсийн бүтээгдэхүүн болох баяжмалыг өтгөрүүлж шүүгээд битүүмжилсэн уутанд хийж савлан, ачааны машинаар Хятад улс руу Гашуун Сухайт/Ганц модны боомтоор дамжуулан тээвэрлэнэ.

Уурхайн үйл ажиллагааны нэмэлт туслах байгууламжид орон нутгийн онгоцны буудал, Хятад улсын хойд хэсэгт орших Өвөр Монголын цахилгаан эрчим хүчний сүлжээнээс өндөр хүчдэлийн шугамаар дамжуулан авах 220 киловаттын (кВ) цахилгаан дамжуулах шугам, нүүрсээр галладаг дулааны төв станц (ДТС), ус хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, засварын цех, агуулах, захиргааны байр, хог хаягдлын байгууламж, түлш хадгалах депо, захиргааны байр, орон сууц, авто зам, тээврийн байгууламж зэрэг орно.

Төсөл 2013 онд ил уурхайгаас олборлолт явуулж эхэлснээр ашиглалтын үе шат нь эхэлсэн. Үүнээс хойш Баяжуулах үйлдвэрээс гарах бүтээгдэхүүний хэмжээ тогтмол өсч, баяжмалыг Хятадын зах дээлд гаргаж байна. Үйлдвэрлэл явуулж эхэлсэн хоёр дахь бүтэн жил буюу 2015 онд баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг сайжруулснаар жилийн эцэст үйлдвэрлэлийн бүтээмж зорилтот хэмжээнээс давсан. 2016 онд 201,300 тонн зэс, 300,000 унци алт үйлдвэрлэсэн. 2017 оны эхний улиралд баяжруулах үйлдвэр өдөрт дундажаар 115 400 тонн баяжмал үйлдвэрлэсэн дээд амжилт тогтоосон. Гэхдээ ОТ 2017 онд 130,000 – 160,000 тонн зэсийн баяжмал, 100,000 – 140,000 унци алтны баяжмал үйлдвэрлэх тооцоотой байна. Үйлдвэрлэл 2016 онтой харьцуулахад буурсан нь үндсэндээ Ил уурхайн одоогийн олборлолт хийж буй хэсгийн зэсийн агуулга нь хорин таван хувиар бага, алтны агуулга нь бараг тавин хувиар бага байгаатай холбоотой.

2013 онд түр зогсолт хийсний дараа Гүний уурхайн үйл ажиллагаа 2016 онд Гүний уурхайн төслийг үргэлжлүүлэх хөтөлбөрийн дагуу дахин эхэлж, 2017 онд Гүний уурхайн 2-р шатанд шаардлагатай нөөц, хүн хүчээ бүрдүүлж эхэлсэн. Хөндлөн нэвтрэлт, уурхайн дэд бүтэц, хүдрийн биетэд хүрэх тоног төхөөрөмж, туузан дамжуулагчийн барилга угсралтын ажлууд бүгд чанарын түвшинд, аюулгүй ахиж урагшилж байна. 2-р босоо амын нэвтрэлт 1,249, 5-р босоо амын нэвтрэлт 878 метрт тус тус хүрч 2017 оны 3-р улиралд 5-р босоо амын ажлын явц хамгийн дээд хэмжээнд хүрсэн. Налуу малталтын ажил гадаргаас доош 600 метрт хүрч нэмэгдсэн байна. Анхдагч бутлуурыг ашиглалтад оруулж, засварын газар, уурхайчдын хувцас солих байр болон бусад байгууламжийн ажил ч мөн ахицтай байна. Олон улсын гэрээт компаниудтай түншилсэн орон нутгийн компаниуд төсөлд хувь нэмрээ оруулж байна. Гүний уурхайн бүтээн байгуулалт, хонгил байгуулах ажлууд дуусмагц уурхайн төлөвлөгөөний дагуу 2020 оноос эхлэн ил уурхайн биетээс гүний

уурхайн агуулга өндөртэй биетэд олборлолт хийж эхэлснээр зэсийн үйлдвэрлэл үлэмж хэмжээгээр нэмэгдэнэ.

Нүүрсээр галладаг Дулаан төв станцын үйл ажиллагааг сайжруулах, баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг өдөрт 100 мянган тонноос дээш баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай болгож өргөтгөхтэй холбоотой ямар нэгэн шийдвэр гараагүй байна. БОНУАТ-нд тусгасны дагуу эдгээрт хоёуланд нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийлгэх ёстой юм.

### **3.2 ТАЙЛАНГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Энэхүү тайланг дараах байдлаар бүлэг болгон зохион байгуулав:

- 3-р бүлэг – Зөрчлийн хүснэгт;
- 4-р бүлэг – Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, нийгмийн хариуцлагын менежментийн тогтолцоо;
- 5-р бүлэг – Байгаль орчин;
- 6-р бүлэг – Нийгэм;
- 7-р бүлэг – Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа;
- 8-р бүлэг – Соёлын өв.

БОНХЗ-ийн хяналт шалгалтаар илэрсэн үндсэн үр дүнг ажиглалт, тайлбар, зөвлөмж хэлбэрээр энэхүү тайланд тусгасан болно. Хоёр төрлийн үр дүнг багтаасан. Үүнд:

- Үйл ажиллагааны менежментийн төлөвлөгөө ба/эсвэл СОУТТ-д тодорхойлсон Төслийн үүрэг амлалттай холбоотойгоор Илэрсэн зөрчлийн хураангуйлсан хүснэгт (3-р хэсэг) -д харуулсан зөрчлүүд;
- БОНХЗ-ийн багийн гишүүдийн хамтын мэдлэг, туршлагад үндэслэн тодорхойлж, хэсэг болгоны (4-8) төгсгөлд тусгасан, цаашид авах шаардлагатай арга хэмжээ, нээлттэй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөсөн санал зөвлөмжүүд.

БОНХЗ-ийн өгсөн зөвлөмжүүд нь заавал биелүүлэх шаардлага биш тул тэдгээрийг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлага тавигдахгүй. Гэсэн хэдий ч БОНХЗ-ийн өгч байгаа бүх зөвлөмжийг ашигтай, ач холбогдолтой талаас нь харж, хэрэв техник эдийн засгийн талаасаа тохиромжтой бол менежментийн цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Төслөөс хүсэж байна.

## 4 ЗӨРЧЛИЙН ХҮСНЭГТ

Энэ бүлэгт төслийн талбай дээр очиж ажиллах, ОТ төслийн ажилтнуудтай уулзаж ярилцах үеэр ажиглагдсан зүйлс, талбайд ажиллах үед болон хожим бидэнд өгсөн баримт бичигт үндэслэн, мөн бидний ажлын удирдамжтай нийцүүлэн тус тайланд дэвшүүлсэн зөрчил дутагдлыг хүснэгтээр хураангуйлсан болно.

Тухайн зөрчил дутагдал нь ҮАМТ, БОНМХ, ОТ төслийн хяналт шинжилгээний баримт бичиг, журамд тодорхойлсон ОТ төслийн байгаль орчин, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагын хувьд хэр ноцтой болохыг тодорхойлох, ОТ төслийн ашиглалтын үйл ажиллагаа нь зээлдүүлэгч байгууллагуудын Байгаль Орчин, Нийгмийн холбогдох шалгуурт хэрхэн нийцэж буйг тодорхойлохын тулд хүснэгтийг өнгөөр кодлон ангилсан болно. Өнгөөр кодолсон ангиллыг РТ-ийн ЭМААБООН Менежментийн Системийн ангиллын дагуух ОТ төслийн БОНМТ-нд<sup>8</sup> тодорхойлсон зөрчил дутагдлын ижил түвшинд үндэслэн оноосон юм.

Дараах байдлаар тайлбарлав:

- **IV ангилал** - Төслийн стандарт эсвэл Менежментийн төлөвлөгөөг ноцтой зөрчсөн бөгөөд экологийн эсвэл нийгмийн чухал нөөц, эмзэг хүлээн авагчдад нөхөж баршгүй нөлөөлөл эсвэл ихээхэн хор хохирол учруулсан буюу учруулж болзошгүй эсвэл эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ноцтой осол эндэгдэл учруулж болзошгүй маш ноцтой зөрчил.
- **III ангилал** - Төслийн стандарт эсвэл Менежментийн төлөвлөгөөг ноцтой зөрчсөн бөгөөд экологийн эсвэл нийгмийн чухал нөөц, эмзэг хүлээн авагчдад нөхөж баршгүй нөлөөлөл эсвэл ихээхэн хор хохирол учруулах эсвэл эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ноцтой осол эндэгдэл учруулах нь тодорхой илрээгүй хэдий ч тийм үр нөлөө үзүүлж болзошгүй бодитой зөрчил.
- **II ангилал** - Төслийн стандарт эсвэл Менежментийн төлөвлөгөөг зөрчсөн хэдий ч экологийн эсвэл нийгмийн чухал нөөц, эмзэг хүлээн авагчдад нөхөж баршгүй нөлөөлөл эсвэл ихээхэн хор хохирол учруулах хэмжээний биш, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ноцтой осол эндэгдэл учруулахааргүй бодитой зөрчил.
- **I ангилал** - Төслийн стандарт эсвэл Менежментийн төлөвлөгөөг бүрэн дагаж мөрдөөгүй бөгөөд байгаль орчин, орон нутгийн ард иргэд эсвэл ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд нөлөөл үзүүлэх магадлал байхгүй.

Хэрэгжүүлэх арга хэмжээг үүрэг даалгаврын дугаараар ангилсан ба (үүрэг даалгаврын Х.Ү дугаар) энд Х нь үүрэг даалгаврын дугаар, Ү нь хэрэгжүүлэх холбогдох арга хэмжээний дугаарыг илтгэж байна. Заавар зөвлөмжийг тодорхойлсон текстийг нэг аудитаас нөгөө аудитын хооронд тухайн үеийн нөхцөл байдлыг илүү тодорхой тусгаж өгөхийн тулд хянаж засвар оруулах шаардлагатай гэдгийг цохон тэмдэглэх хэрэгтэй.

Гэхдээ анхны дугаарууд нэг ижил үндсэн асуудалд хамаарч байгаа учраас тухайн асуудлыг шийдвэрлэж хаах хүртэл хэвээр үлдээлээ. Хүснэгтэд тодорхойлсон төсөлтэй холбоотой зөрчил тус бүрт ОТ ямар нэгэн арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд БОНХЗ дараагийн удаа ажиллахдаа биелэлтийг нь шалгана. Хүснэгтэд мөн илрүүлсэн зүйлсийн тодорхойлолт, оноосон зөрчлийн түвшин, Төслийн хүлээсэн үүрэг хариуцлагад хамаарч буй холбогдох баримт бичиг, мөн БОНХЗ-ийн хамтын мэдлэг туршлага дээр үндэслэн өгч буй засаж залруулах буюу сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүд багтаж байна. БОНХЗ-ийн үзэж байгаагаар зөрчлийг хангалттай хэмжээнд шийдвэрлээгүй тохиолдолд, нөхцөл байдлаас шалтгаалаад бодит үр дагавраас үл хамааран зөрчлийн ангилал нэмэгдэж болзошгүй гэдгийг санах хэрэгтэй ба ямар нэгэн засаж залруулах арга хэмжээ авахаас зайлсхийсэн тохиолдолд үндэслэлтэй тайлбар шаардлагатай юм.

Ерөнхийдөө аудитын үр дүнг дараах байдлаар тодорхойлов:

- IV ангилалд хамаарах зөрчил илрээгүй;
- III ангилалд хамаарах зөрчил илрээгүй;
- II ангилалд хамаарах зөрчил илрээгүй;
- I ангилалд хамаарах зургаан зөрчил илэрсэн.

Доорх хүснэгтэд БОНХЗ 2013 оны 10-р сард уурхайд ирж аудит хийснээс хойш илэрсэн зөрчлүүдийн төлвийг нэгтгэн харуулав.



ХҮСНЭГТЗ.1: БОНХЗ-ийн илрүүлсэн зөрчлийн статус

Даалгаврын д/д.	Уурхайд хийсэн аудит	Шинээр бүртгэгдсэн зөрчил Илэрсэн	Зөрчил Хаасан	Хаагдаагүй зөрчил
M1	2013 оны 10-р сар	26	хамаарахгүй	хамаарахгүй
M2	2014 оны 4-р сар	11	8	29
M3	Баримт бичгийн аудит 2014 оны 8-р сар	2	3	28
M4	2014 оны 11-р сар	7	10	25
M5	Баримт бичгийн аудит 2015 оны 4-р сар	0	3	22
M6	2015 оны 9 сар	4	6	20
M7	Баримт бичгийн аудит 2016 оны 4-р сар	1	9	12
M8	8-р сарын 2016	4	2	14
M9	2017 оны 5-р сар	1	6	9
M10	2017 оны 10 сар	0	3	6

Тэмдэглэл.

Ус, бохир усны менежментэд тусад нь 2017 оны 12-р сард аудит хийх учраас энэ тайланд ороогүй. Баримт бичгийн дугаар 13-391-Н12, хувилбар 0, 2018 оны 1-р сар

АрАЙЭНЭЙ Консалтинг компани

“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

ХҮСНЭГТ 3.2: Зөрчлийн хүснэгт

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
<b>Байгаль орчин – Ус, хаягдал усны менежмент</b>							
M2.3	14 оны 4 сар 14 оны 8-р сар-баримт бичгийн аудит 14 оны 11-р сар 15 оны 9-р сар Баримт бичгийн аудит 2016 оны 4-р сар 16 оны 8-р сар 2017 оны 5-р сар		УХШТ-нд тусгасан нэмэлт хяналтын цооногуудыг өрөмдөж тоноглох ажлыг хараахан хийгээгүй байна.	I	УХШТ, 3.2.6, 3.3.5 хэсэг  Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө (WR14, WRm06)	нээлттэй	5.1.2.9 хэсгийг үзнэ үү. УХШТ-нд зааснаар нэмэлт хяналтын цооногуудыг өрөмдөж тоноглох ажлыг бүрэн хийж дуусаагүй байна. 2016 оны хээрийн ажлын улиралд нийт 200 цооног нэмж гаргасан ба өмнө нь цөөн тооны хяналтын цэгтэй байсан ХХБ-ийн зүүн өмнөд хэсэгт 11 фезометр нэмж суурилуулсан. 2017 оны талбайн ажлын үеэр Гүний хоолойн бүсэд нэмэлт хяналтын цооног гаргах болно. (гурван газарт есөн цэг гаргана). ОТ ойрын хугацаанд нэмэлт хяналтын цэг байгуулах төлөвлөгөө батлагдсан байгаа тул энэ зөрчлийн ангиллыг II байсныг I болгож буурууллаа.
<b>Байгаль орчин – Агаарын чанар</b>							
M1.11	13 оны 10-р сар 14 оны 4-р сар 14 оны 8-р		Том ширхэгтэй хүдрийн овоолгоос их хэмжээний тоос (тоосонцор) ялгардаг. Хөөсөөр тоос дарах систем суурилуулсан бөгөөд ажиллуулж байгаа үед	I	Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөө	нээлттэй	5.5.2.1. хэсгийг үзнэ үү. Том ширхэгтэй хүдрийн овоолгын (ТШХО) байгууламж тоосжилт ихтэй байсаар ирсэн. Үйл ажиллагаанд хэд хэдэн удаа өөрчлөлт оруулж, хэд хэдэн төрлийн арга хэмжээ хэрэгжүүлснээр Хүдрийн овоолгын байгууламж орчмын агаарт тогтсон нийт тоосны нягтрал

АрАЙЭнЭй Консалтинг компани

“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	сар-баримт бичгийн аудит 14 оны 11-р сар Баримт бичгийн аудит 15 оны 4-р сар 15 оны 9-р сар Баримт бичгийн аудит 16 оны 4-р сар 16 оны 8-р сар 2017 оны 5-р сар, 10-р		ерөнхийдөө сайн үр дүнтэй байгаа. Орчны агаарын чанарт хяналт шинжилгээ хийх илүү дээр арга хэрэглэснээр эдгээр арга хэмжээний үр дүнг илүү баримттай тайлбарлах боломжтой болно.				<p>(TSP) нүдээр харахад багассан харагдаж байна. Тоосжилт буурсныг тоон үзүүлэлтээр нотлохын тулд орчны агаарын хяналт шинжилгээ хийх нь хүндрэлтэй байсан. Учир нь өдийг хүртэл дээжийг сард нэг удаа цуглуулж ирсэн ба салхины нөлөө, тухайн үеийн үйл ажиллагааны онцлогоос мөн хамааралтай байдаг. Орчны агаарын чанарыг тасралтгүй үнэлэх шинэ сүлжээг ашигласнаар тоосжилтыг бууруулах арга хэмжээний үр нөлөөг илүү сайн хянах, тухайн орчин дахь мэдрэг хүлээн авагчдад (голчлон баяжуулах үйлдвэрийн ажилтнууд, Манлай кэмп) үзүүлж буй үр нөлөөг хянах боломжтой болно. ТШХО-ын тоосжилтыг багасгах чухал арга хэмжээ хэрэгжүүлсэн. Хөшиг/хаалт хийх зэрэг ТШХО-ын доторх тоосжилтыг багасгах бусад арга хэмжээнүүдийг ч авч байна.</p> <p>Орчны агаарын чанарын хяналт шинжилгээний дүнгээр баяжуулах үйлдвэр, Манлай кэмп дэх ажиллах хүч хангалттай хэмжээнд хамгаалагдаж байгаа нь батлагдсан тохиолдолд энэ зөрчлийг хаана. М1.12-т дурдсаны дагуу Орчны агаарын чанарын хяналт шинжилгээг харьцангуй сайжруулсан байдлаар удахгүй хэрэгжүүлж эхэлнэ. Энэ мэдээний дүн, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт зэргээс хамааран энэ зөрчлийг хаана. Агаарын чанарын сүлжээг суурилуулж, нэмэлт нөлөөлөл бууруулах арга хэмжээнүүдийг (тоосны хаалт зэрэг) төлөвлөсөн тул энэ зөрчлийг 2-р ангиллаас 1-р ангилал руу бууруулсан ба агаарын чанарын</p>

АрАЙЭнЭЙ Консалтинг компани

“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
							мэдээллийг хянаж үзэх шаардлагатай.
M1.12	13 оны 10-р сар 14 оны 4-р сар 14 оны 8-р сар-баримт бичгийн аудит 14 оны 11-р сар 15 оны 4-р сар-баримт бичгийн аудит 15 оны 9-р сар 16 оны 4-р сар-баримт бичгийн 16 оны 8-р сар 2017 оны 5-р сар, 10-р сар		Одоо ашиглаж байгаа орчны агаарын хяналт шинжилгээний сүлжээ учир дутагдалтай байна. Орчны агаарын чанарыг Төслийн шалгуур үзүүлэлттэй харьцуулан хянахын тулд нэмэлт тоног төхөөрөмж суурилуулах шаардлагатай талаар АЧМТ-нд дурджээ.	I	Агаарт ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөө - (ГГҮ02 Агаарын чанарын хяналт шинжилгээний төлөвлөгөө-2.5, 4.1 хэсэг Хавсралт, В)	нээлттэй	5.5.2.1. хэсгийг үзнэ үү. Өмнөх аудитын тайлангуудад тэмдэглэсэнчлэн, шинэчилсэн АЧШТ-нд заасан үүрэг амлалтаа биелүүлж, орчны агаарын чанарыг Төслийн шалгуур үзүүлэлттэй харьцуулан хянахын тулд орчны агаарын чанарын хяналтын сүлжээг сайжруулах шаардлагатай байна. 2016 оны 4-р улиралд хэрэгцээт тоног төхөөрөмжийг уурхайд авчирч, холбогдох ашиглалтын сургалтыг явуулсан. Одоогоор систем хэвийн ажиллаж, байнгын хяналт шинжилгээний мэдээлэл цуглуулж байна. Агаарын чанарын хяналт шинжилгээний сүлжээ суурилуулах, уг сүлжээнээс хангах мэдээллийг БОНХЗ хянах тул энэ зөрчлийг (2-р ангилал байсныг) 1-р ангиллын зөрчил болгож бууруулсан.
M1.13	13 оны 10		Дулааны төв станцын (ДТС)	I	Агаарт	нээлтт	5.5.2.2. хэсгийг үзнэ үү. ДТС-ын утааны чанарын

АрАЙЭнЭй Консалтинг компани

“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	сар 14 оны 4-р сар Баримт бичгийн аудит 14 оны 8-р сар 14 оны 11-р сар Баримт бичгийн аудит 15 оны 4-р сар 15 оны 9-р сар 16 оны 4-р сар-баримт бичгийн 16 оны 8-р сар 2017 оны 5-р сар, 10-р сар		болон Ханбогдын нисэх онгоцны буудалд ашиглаж буй уурын зуухны утаанаас авсан дээж төслийн стандартыг хангаж чадахгүй байна.		ялгарах хийн хаягдлын менежментийн төлөвлөгөө  Агаарын чанарын хяналт-шинжилгээний төлөвлөгөө – Б Хавсралт)	эй	үзүүлэлт Төслийн стандартад хүрсэн удаа үгүй бөгөөд энэ асуудал байнга тавигдсаар ирсэн. Станцын утаанд хяналт шинжилгээ хийсэн хөндлөнгийн байгууллагын дүгнэлтээр утаанаас дээж авахад хэрэглэж байгаа аргачлалд хэд хэдэн дутагдалтай тал байгааг илрүүлсэн. АЧХШТ-ний шаардлагын дагуу ДТС-ыг 130 мВт-д шилжүүлэх 2 дахь шатны өргөтгөлийн ажлын хүрээнд Утааны тогтмол хяналт шинжилгээний систем (УТХШС)-ийг үндсэн нэг янданд суурилуулна. Бүх бойлеруудад бүрэн засвар үйлчилгээ хийсэн, нийт 1,500 гаруй уутат шүүлтүүр сольсон зэрэг бусад сайжруулалтын ажлууд ДТС-д мөн хийгдсэн.  ОТ хамгийн сайн боломжит технологийг төслийн стандартуудад нийцүүлэн хэрэглэж байгаа тул энэ зөрчлийг 1-р ангиллын зөрчил болгон бууруулсан. Гэхдээ Өөрчлөлтийн тэмдэглэл 2017-001-ээр батлагдсан төслийн өөрчлөгдсөн стандартад заасан тоон босгоор тодорхой илэрхийлэгдсэн мэдээллийг Утааны тогтмол хяналт-шинжилгээний системээс гарган авна.
M2.4	14 оны 4-р сар	17 оны 10-р сар	Шатаах зуухны утаанаас авсан дээж төслийн стандартыг	I	Агаарт ялгарах хийн хаягдлын	Хаасан	5.5.2.2 хэсгийг үзнэ үү. Шатаах зуухны утааны чанарын үзүүлэлт Төслийн стандартад хүрэхгүй байгаа асуудал урт хугацаанд үргэлжилж байна.

АрАЙЭнЭй Консалтинг компани

“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	14 оны 8-р сар баримт бичгийн аудит 14 оны 11-р сар Баримт бичгийн аудит 15 оны 4-р сар 15 оны 9-р сар Баримт бичгийн аудит 16 оны 4-р сар 16 оны 8-р сар 2017 оны 5-р сар		хангаж чадахгүй байна.		менежментийн төлөвлөгөө  Агаарын чанарын хяналт-шинжилгээний төлөвлөгөө – С Хавсралт)		ОТ сард 100 кг орчим хэмжээтэй үлйдвэрлэгддэг эмнэлгийн хог хаягдлыг шатаах автоклавтай нэгэн компанитай гэрээ байгуулсан. Тос арчсан даавуу зэрэг бусад аюул учруулж болзошгүй хог хаягдлыг хаягдлын менежментийн төвд тусгай шугам/дамжлага гарган зохицуулж болох юм. Шатаах зуухыг ашиглалтаас гаргах ажил явагдаж байгаа тул энэ зөрчлийг 1-р ангиллын зөрчил болгосон Энэ нэгж 2017 оны 8-р сараас хойш ажиллахгүй байгаа. Аюул учруулж болзошгүй хог хаягдлыг зайлуулах, зохицуулахад боломжит бусад арга замыг (тостой даавуу, эмнэлгийн хаягдлыг автоклавт шатаах зэрэг) ашиглах юм.
<b>Байгаль орчин – Биологийн олон янз байдал, экологийн менежмент</b>							
M8.2	16 оны 8-р сар 2017 оны 5-р сар, 2017 оны		Автозамын нөлөөллийг бууруулах стратеги	I	БОЯБУАТ (13)	нээлттэй	5.9.2.5. хэсгийг үзнэ үү. ОТ нь а) автозам хаах, замын хөдөлгөөний хязгаарлалт тогтоох б) бүсийн түвшний тогтвортой хөгжлийн асуудалтай холбоотой нөлөөллийг бууруулах тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх тал дээр холбогдох

АрАЙЭнЭй Консалтинг компани

“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	10-р сар						<p>байгууллага, эрх бүхий этгээдүүдтэй албан ёсоор хамтран ажиллах с) ОТ-Гашуунсухайт зам, бусад ОТ-н эзэмшлийн бус замууд дээр замын хөдөлгөөний хяналт тавих, тэдгээрийн ан амьтдад үзүүлэх нөлөөлөлд хяналт шинжилгээ хийх зэрэг асуудлуудыг тусгасан ОТ-Гашуунсухайт замын нөлөөллийг бууруулах стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг авсан.</p> <p>БОЯБУАТ-тэй холбоотойгоор ОТ болон зээлдүүлэгч нар замын нөлөөллийг бууруулах стратегийг үнэлэх хөндлөнгийн шинжээчдийн зөвлөл байгуулахаар тохиролцсон. Хөндлөнгийн шинжээчдийн зөвлөл ажлаа гүйцэтгэж тайлангаа гаргасныг БОНХЗ энэхүү аудитын шалгалдаа ашигласан.</p> <p>Зөвлөлийн тайланд ОТ-ГШ чиглэлийн зам өмнөд говийн бүс нутагт орших цагаан зээр, хулангийн тоо толгойд материаллаг эрсдэл учруулахгүй байна гэж дүгнэсэн.</p> <p>100 орчим км замд хийсэн цагаан зээр, хулан зэрэг нүүдэллэдэг амьтдын замаас дайжиж байгаа байдалд хийсэн хяналт шинжилгээний үр дүнд тодорхой үр дүн гараагүй. Замын нөлөөллийн бууруулах хяналтын зөвлөлийн төхөөрөмж суулгасан амьтдаас авсан мэдээлэлд үндэслэн дүгнэлтэй эдгээр амьтад замаас дайжихаас илүү малаас дайждаг гэсэн байна. Нийт туурайтан амьтдын шилжилт хөдөлгөөний хувьд нүүдэллэхэд учирч байгаа саад бэрхшээл төрөл зүйл бүрийн хувьд янз бүр байгаа тул нөлөөлөл бууруулах стратеги үүнийг анхаарч</p>

АрАЙЭнЭй Консалтинг компани

“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
							<p>үзэх нь зүйтэй. Өргөн уудам нутагт тархсан тоо толгойн хувьд хэсэг газрын нөлөөллийг тодорхойлох нь хүндрэлтэй гэдгийг Зөвлөл хүлээн зөвшөөрсөн тул ОТ энэ асуудлыг мэдээлэл цуглуулах өнөөгийн аргачлалдаа хэрхэн тусгах талаар судалж байна. Замын нөлөөллийн бууруулах зөвлөл ОТ-н зүгээс эдгээр төрөл зүйлүүдэд эерэг нөлөө ахиу үзүүлэхэд хувь нэмэр оруулах хамгийн зөв арга бол биологийн төрөл зүйлийн дүйцүүлэн хамгааллын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх явдал ба энэхүү хөтөлбөр нь ОТ-ГШ зам бус харин бэлчээрийн нөөц бүхий газруудад анхаарал хандуулж, Өмнө говийн нутаг дэвсгэрт урт хугацаанд хуримтлагдсан сөрөг нөлөөллийг багасгах улмаас хөтөлбөрийн үр дүнд олж авах шинжлэх ухааны мэдлэгийг уг хүчин чармайлтыг бэхжүүлэн дэмжих явдал гэж зөвлөсөн.</p> <p>Түүнчлэн зөвлөл устаж болзошгүй эрсдэл өндөртэй, судлагдсан байдал хомс тул хар сүүлт зээрийг судлах тал дээр илүү анхаарал хандуулахыг зөвлөсөн. Биологийн олон янз байдлын хяналт шинжилгээний 2018 оны төлөвлөгөөнд хар сүүлт зээрэнд GPS төхөөрөмж суулгах ажил төлөвлөгдсөн.</p> <p>Санал болгосон өөрчлөлтийг бодитоор хэрэгжүүлэхийн өмнө зэрлэг амьтдын хяналт шинжилгээний ажилд шууд оролцоотой байгууллагуудтай зөвлөлдөж, тэдний зөвлөмжийг тайлангийн дүгнэлт зөвлөмждөө оруулахыг Зөвлөл зөвлөсөн. ОТ, Састэнэбилити Ийст Эйжиа болон Зэрлэг амьдыг хамгаалах</p>



АрАЙЭнЭй Консалтинг компани

“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
							<p>нийгэмлэгийн ажилтнуудтай 2017 оны 10-р сарын 31-нд зөвлөмжийн сүүлийн хувилбарыг хэлэлцэх уулзалт хийсэн. Түүчнлэн автозамын нөлөөллийг бууруулах стратегийг 2017 оны 4-р улиралд багтаан шинэчлэн боловсруулахтай холбогдуулан Зээлдүүлэгчдийн төлөөлөгчдийн санал зөвлөмжийг авах уулзалт хийсэн.</p> <p>ОТ, Зээлдүүлэгч Нөлөөлөл бууруулах стратегийн хүрээнд цаашид хийх ажлаа харилцан тохиролцох (БОЯБУАТ-ний дагуу) хүртэл Автозамын нөлөөллийг бууруулах стратегитай холбоотой зөрчил нээлттэй хэвээр үлдэж байна.</p> <p>Гэхдээ энэ зөрчлийн шийдвэрлэр явц ахицтай байгаа тул II -р ангиллаас I ангилал руу бууруулсан.</p>
M8.3	16 оны 8-р сар 2017 оны 5-р сар	2017 оны 10-р сар	Ургамлын хяналт-шинжилгээний талбай байгуулж, тоосжилтоос бэлчээрт үзүүлж болзошгүй нөлөөлөлд хяналт шинжилгээ хийх	I	БОЯБМТ	Хаасан	<p>5.9.2.6. хэсгийг үзнэ үү. Төслийн хувьд бэлчээрийн мал аж ахуйг экосистемийн чухал үйлчилгээ гэж үздэг бөгөөд барилгын үе шатанд тоосжилтын түвшин нэмэгдсэнээс ургамал ургалтыг дарангуйлж байгаа тухай санал гомдлын мөрөөр ОТ (Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд) тоосжилтоос бэлчээрт үзүүлэх болзошгүй нөлөөллийг хянах зорилгоор хяналт-шинжилгээний талбай байгуулах арга хэмжээ авсан.</p> <p>ОТ-н үйл ажиллагаанаас үүсч байгаа тоосжилт бэлчээрийн ургамал ургалтад нөлөөлөх магадлал байхгүй ч гэсэн үүнийг нотлох мэдээ баримт байхгүй учир цаашид үүнтэй холбоотой гарах санал гомдолд хариу өгөх үндэслэл</p>

АрАЙЭНЭЙ Консалтинг компани

“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
							байхгүй байгаа юм. ОТ ерөнхийдөө энэ асуудлын учрыг тайлж, тоосжилтын хяналт үнэлгээ хийх хэрэгцээг шаардлагыг тогтоох үнэлгээ хийх шаардлагатай. Өмнөх аудитаас хойш хийгдгээгүй. Өмнөх аудитаас хойш тоожилтийн хяналт-шинжилгээнд зарим ахиц гарсан. 8-р сард профессор Болдгив болон түүний багтай ургамлын байнгын хяналт шинжилгээний 32 талбайд тоосжилтийн хяналт шинжилгээ хийх гэрээ байгуулсан. Тоосжилтийн бэлчээрт нөлөөлөх нөлөөний талаар судлах судалгааны аргачлалыг боловсруулж судалгааны талбайг 2 чиглэлийн дагуу сонгосон. Хээрийн судалгааг 2017 оны 9-р сард хийж дуусгасан. Энэхүү судалгааны үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг 2017 оны 4-р улиралд өгөх гэрээт гүйцэтгэгчдийн тайланд оруулна. Энэ ажил явагдаж байгаа тул уг зөрчлийг хаав.
М9.1	2017оны 5-р сар	2017 оны 10-р сар	Ховор ургамлын зүйл үржүүлэх	I	БОЯБХҮТ (Хавсралт 1) (ОТ-10-Е14-PLN0003) YAMT (ОТ-10-Е14-PLN-0007) Хүснэгт 9 Газар хөндөх журам (ОТ-	Хаасан	5.9.2.4; 5.9.2.8. хэсгийг үзнэ үү. Ховор ургамлын зүйлийг хамгаалах, төсөлтэй холбоотой нөлөөллийг бууруулах арга хэмжээг Газар хөндөх, ховор ургамлын зүйлийг хамгаалах журамд оруулж өгсөн ба тэдгээр арга хэмжээг нөлөөлөл бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх эрэмбийн дагуу хэрэгжүүлнэ. Ховор ургамлыг хамгаалах журамд ховор ургамалд сөрөг нөлөө үзүүлсэн эсвэл үзүүлж болзошгүй нөхцөлд ОТ ховор ургамлын зүйлийг ургуулах арга технологийг боловсруулах, ялангуяа ховор зүйлийн үржүүлгийн судалгаа хийх ёстой гэж заасан байдаг.

АрАЙЭнЭй Консалтинг компани

“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
					10-E14-PRC-0003-E)  Ховор ургамал хамгаалах журам (ОТ-10-E14-PRC-0007-E)		<p>ОТ ховор ургамлын төрөл зүйлийг хамгаалах механизм хэрэгжүүлж байгаа хэдий ч 2017 оны 5-р сард хийгдсэн өмнөх аудитаар ховор ургамал, түүний дотор Грубовын хөөндийтэй холбоотой зөрчил илрүүлсэн. Энэ зөрчлөөр ОТ-д бүх төрлийн ховор ургамлын үржүүлгийн судалгааны цогц хөтөлбөр боловсруулах шаардлага тавигдсан.</p> <p>Энэхүү зөрчил мөн ховор ургамлын төрөл зүйлийн талаар Зээлдүүлэгчдийн санаа зовниж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор ОТ урт богино хугацааны төлөвлөгөө боловсруулж, Нутгийн ургамлын үржүүлгийн төвийн ховор ургамлын төрөл зүйлийг үржүүлэх чадамжийг сайжруулах улмаар нөхөн сэргээлтийн тариалалтад ховор ургамлын төрөл зүйлийг оруулах чиглэлээр тодорхой үйл ажиллагаануудыг багтаасан хөтөлбөр боловсруулсан. Түүнчлэн БОНХЗ-д мэдээлснээр Биологийн олон янз байдлын хяналт шинжилгээний төлөвлөгөөний судалгаагаар Грубовын хөөндийн бүлгэмдлийг Ханбогд сум болон УЛТ-ын талбайн гадна талд олон тоогоор, зэргэлдээх сумдад мөн илрүүлсэн байна. Ховор ургамлын зурагдлалын сайжруулах, ургамлын бичил амьдрах орчны ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор ховор ургамлын судалгаа, амьдрах орчны нарийвчилсан үнэлгээг 2018 онд уурхайн лицензийн талбайд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.</p> <p>Энэ асуудлыг шийдвэрлэх талаар нэлээд ахиц гарч байна гэж БОНХЗ үзэж байна. Үржүүлгийг</p>

АрАЙЭнЭй Консалтинг компани

“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
							аргыг боловсронгуй болгоход чиглэсэн судалгааны төслийг 2018-2020 онд хэрэгжүүлэхээр боловсруулсан бөгөөд ОТ цаашид ч ховор ургамлын төрөл зүйлийг нөхөн сэргээлтэд амжилттай хамруулахын тулд амьдрах орчны шаардлагуудын талаар мэдлэгээ нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Энэ аудитаар уг зөрчлийг хаав.
<b>Нийгэм –Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, амьжиргаа сайжруулах</b>							
M1.23	13 оны 10-р сар 14 оны 4-р сар 14-оны 8-р сар-баримт бичгийн аудит 14 оны 11-р сар 15 оны 4-р сар-баримт бичгийн аудит 15 оны 9-р сар 2016 оны 4-р сар-баримт		Нөлөөлөлд өртсөн малчдад чиглэсэн хөтөлбөрүүдэд Үр дүнгийн үнэлгээ хийх нь Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөнд заасан үүрэг бөгөөд Ханбогд сумын эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн болон бусад нөлөөлөлд өртсөн малчдыг хамарсан үр дүнгийн үнэлгээ хийх хугацаа болсон байна.	I	Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (10.1, 10.2, 10.4-р хэсэг)	нээлттэй	6.3.2.2. хэсгийг үзнэ үү. Олон талт шинжээчдийн баг (ОТШБ) -ийн судалгаа 206 оны эхээр эхэлж багийн бүрэлдэхүүнийг сонгож, аргачлал, хугацааг хэлэлцэж судалгаанд хэрхэн оролцох талаар тохиролцсон. Хээрийн судалгааны ажил 2016 оны 5-р сард эхэлж 110 өрхөөс ярилцлага авсан ( төлөвлөснөөс <b>10-р илүү</b> ). Энэ ажил 2017 оны 1-р улиралд дууссан. Энэ чиглэлээр бодитой ажлууд хийж, ахиц гаргасан нь сайн хэрэг ч гэлээ үр дүнгийн үнэлгээ хийх ажлыг хийгээгүй хэвээр байна. Ханбогдын нөлөөлөлд өртсөн малчдын дунд үр дүнгийн үнэлгээ хийх ажлын явц ихээхэн хойшлогдсоор ирсэн бөгөөд дээрх судалгааны дүн цаг хугацаандаа гарах нь чухал. 2016 оны 8-р сард хийсэн аудитын үеэр БОНХЗ талууд амжилтад хүрсэнийг хэмжих үзүүлэлт буюу ‘үр дүн’-д хүрсэн гэж үзэх үзүүлэлтийг харилцан тохиролцсоноор яваандаа эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой зөрчлийг хаахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэж зөвлөсөн. ОТШБ-ийн судалгаа одоо дууссан ба энэ зөрчил нээлттэй хэвээр үлдсэн.

**АрАЙЭнЭй Консалтинг компани**

**“ОЮУ ТОЛГОЙ” УУРХАЙН ТӨСӨЛ**

Үүрэг / асуудлын д/д.	Уурхайд хийсэн аудит	Хаагдах өдөр	Тайлбар	Зөрчил	Лавлах баримт бичиг	Төлөв	Тайлбар / холбогдох тайлан
	бичгийн аудит 16 оны 8-р сар 17 оны 5-р сар 17 оны 10-р сар						2017 оны 5-р сард Орон нутгийн харилцааны баг Үр дүнгийн үнэлгээ хийх байгууллага сонгон шалгаруулах зар гаргасан бөгөөд энэ ажил дээр нэмэлт, техникийн зөвөлгөө авах чиглэлээр Зээлдүүлэгчид, БОНХЗ-тэй хамтран ажилласан. 2017 оны 11-р сард зөвлөх томилогдсон ба хээрийн судалгааны ажлыг 11, 12-р саруудад гүйцэтгэхээр төлөвлөсөн ба эцсийн тайланг 2017 оны 12-р сард өгнө. Үр дүнгийн үнэлгээг амжилттай хийж дуусах хүртэл энэ зөрчил нээлттэй байна.

